



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 4/254

Улаанбаатар хот

“Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ,  
мэдээлэл, үйлчилгээний ажлыг дүгнэх  
журам”-ыг батлах тухай

Монгол улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.7 дахь заалт, тус газрын Арга зүйн зөвлөлийн 2023 оны 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлыг дүгнэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлыг дүгнэх журам”-ыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажилсугай.
3. Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг газрын хэлтсийн дарга нар, харьяа байгууллагуудын дарга, захирал, Аймаг, нийслэлийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт тус тус даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журмуудыг шинэчлэн батлах тухай” Газрын даргын 2015 онд А/171 дүгээр тушаалаар батлагдсан журмыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ  
ХЭЛТСИЙН ДАРГА

ЛОЮУНЖАРГАЛ



Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын  
2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн  
A/257 дугаар тушаалын хавсралт



**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВҮҮДИЙН  
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫГ ДҮГНЭХ ЖУРАМ**

1. Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүд цаг уур, хөдөө аж ахуй, ус судлалын өртөө, харуулын ажлыг дүгнэх
2. Төвийн мэргэжлийн байгууллагууд Аймаг, нийслэлийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлыг дүгнэх
3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын оны тэргүүний өртөө, харул, лаборатори, экспедиц, нислэгийн цаг уурын үйлчилгээ шалгаруулах

**Товчилсон үгийн жагсаалт:**

ЦУОШГ – Цаг уур, орчны шинжилгээний газар  
УЦУОСМХ – Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн  
УСУАҮХ – Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтэс  
ОШХ - Орчны шинжилгээний хэлтэс  
НЦУТ – Нислэгийн цаг уурын төв  
ИНЕГ – Иргэний нисэхийн өрөнхий газар  
УЦУОШТ – Ус цаг уур, орчны шинжилгээний төв  
ХААЦУ – Хөдөө аж ахуйн цаг уур  
ХААЦУСХ- Хөдөө аж ахуйн цаг уурын судалгааны хэлтэс  
БОХЗТЛ – Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори  
БОШЛ - Байгаль орчны шинжилгээний лаборатори  
БОУЦУ – Байгаль орчин, ус цаг уур  
СМ – Сээрэмжлүүлэх мэдээ  
УСМ – Урьдчилан сэргийлэх мэдээ  
АМ – Анхааруулах мэдээ  
АҮ – Аюултай үзэгдэл  
ГҮ – Гамшигт үзэгдэл  
ХСМ – Хоногийн сээрэмжлүүлэх мэдээ  
НСМ – Нарийвчилсан сээрэмжлүүлэх мэдээ  
НУСМ – Нарийвчилсан урьдчилан сэргийлэх мэдээ  
ХУСМ – Хоногийн урьдчилан сэргийлэх мэдээ  
ХТ – Хуурамч түгшүүр

Аймаг, нийслэлийн УЦУОШТ-үүд нь цаг уур, хөдөө аж ахуй, ус судлалын өртөө, харуулын хөтөлбөрт шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын чанарыг сар бүр дүгнэж мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

### **НЭГ. УЦУОШТ-ҮҮД ЦАГ УУР, ХӨДӨӨ АЖ АХУЙ, УС СУДЛАЛЫН ӨРТӨӨ, ХАРУУЛЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫГ ДҮГНЭХ**

Аймаг, нийслэлийн УЦУОШТ нь шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын чанарыг дараах өртөө, харуулаар дүгнэнэ. Үүнд:

- ✓ Цаг уурын өртөө, харуул
- ✓ ХААЦУ-ын өртөө, харуул
- ✓ Ус судлалын харуул

#### **1.1 ЦАГ УУРЫН ӨРТӨӨ, ХАРУУЛ**

Цаг уурын өртөө, харуулын шинжилгээний ажлыг:

- хөтөлбөрийн биелэлт
- тайлангийн ирц
- ажиглалтын чанар
- материал боловсруулалт
- мэдээ зохиолт гэсэн 5 үзүүлэлтээр сар бүр дүгнэнэ. Шалгасан эх мэдээг тухайн төвийн архив, мэдээллийн дэд сан болон УЦУОСМХ-ийн холбогдох нэгжид сар бүр дотоод сүлжээгээр ирүүлнэ.

##### **1.1.1 Хөтөлбөрийн биелэлт**

Өртөө, харуул нь тухайн сард хийх ажиглалтыг хөтөлбөрийн дагуу бүрэн хийсэн бол 100% гэж дүгнэнэ. Хөтөлбөрт заасан аль нэг ажиглалтыг хийгээгүй, дутуу хийсэн, тасалсан тохиолдол бүрд 5%-иар хорогдуулан дүгнэнэ.

**Тайлбар:** Хэрэв нөөц багаж хангалтгүйгээс шалтгаалан ажиглалт тасарсан боловч энэ тухай тодорхой тайлбар бичсэн, арга хэмжээ авсан бол хөтөлбөрийн биелэлтийн дүнгээс хасахгүй.

##### **1.1.2 Тайлангийн ирц**

Ажиглалтын дэвтэр, материал болон эх мэдээ электрон хэлбэрээр хугацаандаа ирсэн бол 100% гэж дүгнэх ба тайлан мэдээ хоцроосон тохиолдол бүрд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Өртөө, харуулын цахим мэдээг сар бүрийн 3-ны дотор, өртөө, харуулын дэвтэр, цаасан тайланг сар бүрийн 5-ны дотор ирүүлсэн байх бөгөөд хугацаа хоцроож ирүүлсэн бол хоцроосон хоног тутамд – 2%
- Жилд 1 сар амрах ба сараас илүү хугацаагаар тайлан мэдээ тасалсан тохиолдолд тасарсан сар тутамд – 20% хасна.

**Тайлбар:** Харуулын ажиглагчийн ээлжийн амралтыг сар дамнахгүйгээр зохицуулалт хийнэ. Өөрөөр хэлбэл харуулын тайлангийн мэдээний тасралт жилд 1 сараас хэтрэхгүй байх ба өвчтэй, чөлөөтэй үед цувааны тасралтгүй байдлыг хангах үүднээс орлон ажиглагч заавал ажиллуулах шаардлагатай.

##### **1.1.3 Ажиглалтын чанар**

Хөтөлбөрт ажлыг заавар, технологийн дагуу үнэн зөв хийсэн бол 100% гэх ба ажиглалт, хэмжил зүйн ямар нэг технологийн зөрчил гаргасан, гологдол болсон бол дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Ажиглалт, хэмжлийн технологи зөрчсэн тохиолдол бүр (анхны тоололтыг арилгаж засссан, багажийн байрлал буруу, гэмтэлтэй багажаар тоололт авах, ажиглалтын хугацаа баримтлаагүй, үзлэг үйлчилгээ, тохируулга хийгээгүй, усалгааны технологи баримтлаагүй тохиолдол бүр г.м) – 2%
- Сарын дүнгээр ажиглалт, хэмжил гологдол болсон тохиолдол бүрд - 10%
- Аль нэг хэмжил, тайлбар тэмдэглэгээ дутуу, буруу тохиолдол бүрд - 2%
- Үүл, үзэгдэл, түүний эрчимшил, алсын барааны харагдац, хөрсний гадаргын байдал, цасан бүрхүүлийн ажиглалт гэх мэт нүдэн баримжааны ажиглалт буруу ажигласан тохиолдол бүрд (ажиглалт хоорондын хугацааны үзэгдэл, салхины өөрчлөлтийг ажиглаагүй бол үүнд хамаарна) – 2%

#### **1.1.4 Материал боловсруулалт**

Ажиглалтын материалыг алдаагүй, цэвэр нямбай боловсруулсан бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Дэвтрийн тэмдэглэл, боловсруулалт хайнга, гаргац муутай бол - 2%
- Зөв ажиглалтын мэдээг дэвтэрт буруу боловсруулсан тохиолдол бүрд /цаг агаарын өнгөрсөн болон ажиглалтын хугацаа W ба WW-ны үзэгдэл, салхины зүг, хурдны шинж байдал, хөрсний гадаргын байдал, тунадасны засвар буруу хийх гэх мэт/ - 2%
- Ажиглалтын мэдээг автомат боловсруулалтын систем /ABC/-д хөрвүүлэхдээ шивэлтийн алдаа гаргасан тохиолдол бүрд -1%. Энд дэвтрийн боловсруулалтад гарсан алдаанаас шалтгаалсныг давхардуулан тооцохгүй.
- Төвийн инженер, техничч нараас өгсөн зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэхгүй, алдааг дараа сард давтан ирүүлбэл – 2%, 3 дахь сардаа давтвал - 3% гэх мэт хувь ноогдуулж хасна.
- ABC-ийн цахим эх мэдээ /sx/-ний блокыг хөтөлбөрийн дагуу бүрэн гүйцэд шивж ирүүлээгүй тохиолдол бүрд – 5% хасна. Үүнд: (99-р блокод тэмдэглэлийг дэлгэрэнгүй бичих, AY-ийн 60-р блокийг зөв шивэх, өөрөө бичигчгүй ч гигограф, термографын бүлгийг автомат станцын бичлэгийн цаг тутмын бичилтээс авч шивэх г.м...)

#### **1.1.5 Мэдээ зохиолт**

Ажиглалтын коод мэдээг ямар ч алдаагүй боловсруулан зохиож, өгвөл зохих нэмэгдэл бүлэг, аюул агаар мэдээг бүрэн дамжуулсан бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Ингэхдээ аюул агаар болон агро дундаж мэдээний алдааг төвийн урьдчилан мэдээлэх хэсэг, хөдөө аж ахуйн цаг уурын хэсэгт хассан алдаатай давхцуулахгүй, нэмэлтээр илрүүлсэн алдаанаас хасаж тооцно. Үүнд:

- Алдаатай коодлосон элемент тус бүр – 1%
- Үндсэн ба нэмэгдэл бүлэг өгөөгүй тохиолдол бүрд – 3%
- Цаг агаарын аюул, агаар мэдээ өгөөгүй бол – 5%
- Аюул агаар болон Агро дундаж мэдээний бүлэг дутуу, буруу өгсөн тохиолдолд – 3% хасна.

### **1.2 ХААЦУ-ЫН ӨРТӨӨ, ХАРУУЛ**

ХААЦУ-ын хөтөлбөрт шинжилгээний ажлыг:

- мэдээний ирц
- хөтөлбөрийн биелэлт
- ажиглалтын мэдээний бүтэц
- ажиглалтын мэдээний чанар гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэнэ. Аймгийн инженерүүд шалгасан мэдээг сар бүрийн 4, 14, 24-ний өдрүүдэд багтааж ХААЦУСХ-т илгээнэ.

#### **1.2.1 Мэдээний ирц**

Мэдээний ирцийг дүгнэхдээ коодын мэдээний бүлгийг тооцох ба хоцроосон бүлэг бүрээс 5%-ийг хасна. Коодын мэдээ нийт 12 бүлэгтэй бөгөөд жишээ нь 3 бүлэг мэдээг орхигдуулсан бол  $3*5\% = 15\%$ ).

#### **1.2.2 Хөтөлбөрийн биелэлт**

Ажиглалтыг хөтөлбөр, технологийн дагуу бүрэн гүйцэд хийж, 10 хоногийн агродундаж мэдээнд коодолж өгнө. Хөтөлбөрийн биелэлтийг дүгнэхдээ тухайн салбарын ажиглалтын үзүүлэлт тус бүрээр дүгнэнэ. Үүнд:

- Тасалсан (шалтгаангүйгээр хийгээгүй) ажиглалт бүрээс 1% хорогдуулж бүлэг тус бүрээр ажиглалт хийгээгүй мэдээний хувийг гаргана. Хөтөлбөрийн биелэлтийг хувилж бодож гаргана. Өөрөөр хэлбэл, тасалсан ажиглалтын мэдээний нийлбэрийг нийт ирүүлсэн мэдээний тоонд хувааж 100-аар үргүүлэн 100 хувиас хасаж хөтөлбөрийн биелэлтийн дүнг салбар бүрээр гаргана. Жишээлбэл, 811\_84 бүлэгт нийт 15 үзүүлэлтийг коодолж ирүүлэхээс 1 элементийг ирүүлээгүй бол  $100-1/15*100=93.3\%$  гэж тооцно.
- Тухайн салбар хөтөлбөрт ажлыг тасалсан буюу огт хийгээгүй бол 100% хасаж дүгнэнэ.
- Цаг уурын бүлгийн мэдээнд хөтөлбөрийн биелэлт дүгнэхгүй.

#### **1.2.3 Ажиглалтын мэдээний бүтэц**

Агродундаж мэдээгээр ирсэн ХААЦУ-ын бүх төрлийн ажиглалтын мэдээнд бүтцийн шалгалтыг 10 хоног тутамд хийж, ажлыг салбар бүрээр дүгнэнэ.

Бүлэгт алдаатай юмуу андуурч коодлосон элемент тус бүрээс 1%-ийг хорогдуулж, алдаатай ирүүлсэн мэдээний тоог бүлэг тус бүрээр гаргана. Алдаатай мэдээний хувь хэмжээг мөн хувилж

бодох аргаар, салбар бүрээр гаргана. Жишээлбэл, 800\_80 бүлэгт 14 элементийг коодолж ирүүлэхээс 1 элементийг буруу өгсөн бол  $100 \cdot 1 / 14 \cdot 100 = 92.9\%$  гэж тооцно.

#### **1.2.4 Ажиглалтын мэдээний чанар**

Аймгийн инженерүүд агродундаж мэдээгээр ирсэн ХААЦУ-ын бүх төрлийн ажиглалтын мэдээг 3-4 хоногийн дотор шалгаж, эргэлзээтэй мэдээг станц, харуулаас лавлаж, шаардлагатай бол зураг, бичлэг авч шалган салбаруудын ажиглалтын чанарыг дүгнэнэ.

Ажиглалтын заавар, технологи баримтлаагүйгээс гаргасан алдаа тус бүрээс 10%-ийг хасна. Хэрвээ тухайн арав хоногт ажиглалтын чанарт алдаа гаргаж хасуулсан бол дараагийн ажиглалтын мэдээг баталгаажуулсан фотографийг болон ажиглалтын дэвтрийн зургийг авч төвд илгээнэ. Агродундаж мэдээгээр ирсэн болон ажиглалтын дэвтрийн мэдээ зөрвөл 1.2.3-ийг баримтлан дүгнэнэ.

### **1.3 УС СУДЛАЛЫН ХАРУУЛ**

Ус судлалын харуулын шинжилгээний ажлыг сар бүр дараах 3 үзүүлэлтээр дүгнэнэ. Үүнд:

- Хөтөлбөрийн биелэлт
- Ажиглалтын чанар
- Материал боловсруулалт

#### **1.3.1. Хөтөлбөрийн биелэлт**

Ус судлалын шинжилгээний хөтөлбөрт ажлыг бүрэн хийсэн байвал 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулах буюу нэмэгдүүлж дүгнэнэ. Үүнд:

- Хугацааны ажиглалтыг тасалсан, ажиглалтад хэрэглэж байгаа багаж төхөөрөмжийг бүрэн байрлуулаагүй, үйлчилгээ хийгээгүй тохиолдол бүрд -5%
- Өнгөрөлт хэмжээгүй (хурд хэмжүүрээр хэмжих боломжгүй үед урсгалын хурдыг хөвүүрийн болон бусад аргаар) тохиолдол бүрд тухайн сард нэг өнгөрөлтөд ногдох хувиар (Жишээ нь, 5 өнгөрөлт хэмждэг сард 1 өнгөрөлт тасалбал - 20%)
- Усны хими, биологийн сорьц аваагүй тохиолдол бүрд -15%
- Тогтмол мэдээ тасалсан тохиолдол бүрд тухайн сард ногдох хувиар, аюул мэдээг тасалсан тохиолдол бүрд - 8%
- Бүх төрлийн тайлан, тогтмол болон аюул мэдээг тогтоосон хугацаанаас хоцроосон хоног тутамд -1%
- Усны түвшин огцом ихсэх, буурах, хавар, намрын усны горимын шилжилтийн үед нэмж хэмжсэн өнгөрөлт бүрд + 5%

#### **1.3.2. Ажиглалтын чанар**

Ажиглалтыг заавар, технологийн дагуу чанартай хийсэн бол 100 хувь, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Хугацааны ажиглалтын хэмжилт, тоололт гологдол болсон тохиолдол бүрд -2%
- Усны температурын ажиглалт ба ёроолдоо хүртэл хөлддөг голд усны түвшний ажиглалтыг хугацаанаас эрт зогсоох, хожуу эхлэх, мөсний үзэгдлийг тогтоосон зайлж хамруулан ажиглаагүй, зөв тодорхойлоогүй, зураглал хийгээгүй, ган татлаганы туугдах өнцөг, урсгалгүй хэсгийн зааг зэргийг тогтоогоогүй, хагшаасны болон усны өнгөрөлтийн хурдны боссоо, цэгийн тоог цөөрүүлсэн, усны ууршил, температур, хурд хэмжих болон бусад ажиглалтын технологийн алдаа тутамд - 3%
- Үер болон хавар, намрын усны горимын шилжилтийн үед усны түвшний олшруулсан ажиглалт хийгээгүй тохиолдол бүр - 4%
- Шонг шинээр зоож ажиглалтыг тасралтгүй хийх нөхцөл бүрдүүлээгүй, зэрэгцээ тоололт хийгээгүй, шаардлагатай үед ууршуулагчид ус нэмж, хасаагүй тохиолдол бүрд -5%
- Голын салаа, усалгааны сувгийн усны өнгөрөлтийг хэмжээгүй бол - 6%
- Сорьцыг тогтоосон цэгээс аваагүй, бохир саванд авсан, тодорхойлох элементүүдийг дутуу, буруу хийсэн, аль нэг сорьцонд бэхжүүлэлт хийгээгүй, дагалдах хуудсыг бүрэн бөглөөгүй тохиолдол бүрд -5%

### 1.3.3. Материал боловсруулалт

Ажиглалтын материалыг нэг ч алдаагүй, цэвэр нямбай боловсруулсан бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Хоног, арав хоног, сарын дүн, дундаж гаргах, их, багыг түүвэрлэх, лавлах хүснэгт хөтлөх, багажийн засварыг хэрэглэх зэрэгт алдсан тохиолдол бурд -1%
- Үзүүлэлтийг буруу тооцож гаргасан /урсгалын дундаж хурд, гүн, зайр, мөс, живсэн мөс, усан отглолын талбай, чөлөөтэй урсах гүн, ус, хагшаас ба халиа тошиngийн өнгөрөлт, булингар, хэвгий, газар доорх усны түвшин, булгийн ундарга, хурд хэмжүүр байрлуулах гүн, сэнсний эргэлтийн дүн, секундэд ногдох эргэлтийн тоо, босоо дээрх хурд, усны ууршил, тунадас хэмжих зэрэг ажилд гарсан алдааны/ тохиолдол бурд - 0.5%
- Тогтмол ба аюул мэдээг буруу, дутуу коодолсон тохиолдол бурд – 5%

**ХОЁР. ТӨВИЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУД  
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ТӨВҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
АЖЛЫГ ДҮГНЭХ**

Төвийн мэргэжлийн байгууллагууд аймаг, нийслэлийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн ажлыг дараах үзүүлэлтээр дүгнэнэ. Үүнд:

1. Цаг уурын шинжилгээний ажлын чанар
2. ХААЦУ-ын шинжилгээний ажлын чанар
3. Ус судлалын шинжилгээний ажлын чанар
4. Орчны хяналт шинжилгээний ажлын чанар
5. Хэмжилзүй, технологийн мөрдөлтийн чанар
6. Мэдээлэл солилцооны ажлын чанар
7. Цаг агаарын урьдчилсан мэдээний чанар
8. Нислэгт үйлчилсэн мэдээний чанар
9. Мэдээллийн сангийн ажлын чанар
10. Цаг агаарт зориудаар нөлөөлж тунадас нэмэгдүүлсэн ажлын чанар

Шинжилгээний ажлыг дүгнэх хугацааг өмнөх оны 12 дугаар сараас 01-ээс тухайн оны 11 дүгээр сарыг дуусталх хугацаагаар дуусгавар болгон тооцож төвийн мэргэжлийн байгууллагууд нь 12 дугаар сарын 05-ны дотор аймаг, нийслэлийн УЦУОШТ-үүдэд жилийн эцсийн дүнг урьдчилсан байдлаар танилцуулсан байна.

### 2.1. ЦАГ УУРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

Цаг уурын шинжилгээний ажлын нэгдсэн дүнг:

- ✓ цаг уур
- ✓ нарны цацраг судлал
- ✓ аэрологийн салбарын шинжилгээний ажлын чанар гэсэн 3 үзүүлэлтийн дундаж дээр төвийн ачааллыг үнэлэх коэффициентийг нэмж нэгдсэн дүнг гаргана.

#### 2.1.1 Цаг уурын салбарын шинжилгээний ажил

- анхан шатны шүүмж шалгалт
- ажиглалтын чанар гэсэн 2 үзүүлэлтийн дунджаар дүгнэнэ.

##### 2.1.1.1. Анхан шатны шүүмж шалгалт

Анхан шатны шүүмж шалгалтын чанарыг дараах байдлаар 100%-иас хорогдуулж дүгнэнэ.

Үүнд:

- Ажиглалтын технологийн алдааг илрүүлээгүй тохиолдол бүр - 2%  
Үүнд: багажийн байрлал шалгах, үзлэг үйлчилгээ, засвар тохируулга хийгээгүй, усалгааны технологи баримтлаагүй, г.м.
- Гологдол ажиглалтыг анхан шатны шүүмж шалгалтаар илрүүлээгүй бол - 10%
- Гологдол болсон мэдээг эх мэдээнээс арилгаагүй, тайлбар ирүүлээгүй, дүгнэх журам баримтлаагүй тохиолдол бурд – 3%

**Тайлбар:** Эргэлзээтэй мэдээг арилгахгүй харин тэмдэглэл бичнэ. Жишээ нь, гэмтэлтэй багажаар хийсэн ажиглалт, хуурамч ажиглалт г.м.

- Үүлний төрөл, үүл, үзэгдлийн уялдаа, үзэгдлийн эрчимшил, үргэлжилсэн хугацаа, завсрын хугацааны дундаж их салхи г.м ажиглалтын чанарын алдааг илрүүлээгүй буюу буруу зассан тохиолдол бүрд - 2%
- Дүгнэх журмыг баримтлаагүй тохиолдол бүрд -1%
- Бүтцийн шалгалтын алдаатай мэдээ ирүүлсэн тохиолдолд алдаа тутмаас - 3%
- Утгын шалгалтаар илрүүлсэн алдааг хүлээн зөвшөөрсөн тухай тайлбар ирүүлээгүй, утгын шалгалтаар засагдах алдааг засаагүй (өнгөрсөн болон ажиглалтын хугацааны цаг агаарын байдал, тунадасны засвар буруу хийсэн) тохиолдол бүрд - 1%
- Тайлан мэдээг хоцроосон бол хоног тутамд - 3%

**Тайлбар:** Өртөөний тайланг урьдчилсан байдлаар дараа сарын 5-ны, төвийн бүх салбарын тайланг нэгтгэн 20-ны дотор УЦУОСМХ-ийн цаг уурын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ)

- Шүүмж хийгээгүй тохиолдолд - 100%

Шаардлагатай тохиолдолд УЦУОШТ-өөс өртөө, харуулын ажиглалтын эх материалыг УЦУОСМХ-ийн Цаг уурын асуудал хариуцсан нэгж авч шалган, ажиглалтын чанарт хяналт тавина.

### 2.1.1.2. Ажиглалтын чанар

Аймаг, нийслэлийн УЦУОШТ-өөс ирүүлсэн үнэлгээнээс анхан шатны шүүмж шалгалтаар илрүүлээгүй алдааг дараах байдлаар хувь хорогдуулан дүгнэнэ. Үүнд:

- Ажиглалт, хэмжлийн технологи зөрчсөн тохиолдол бүр (анхны тоололтыг арилгаж зассан, багажийн байрлал буруу, ажиглалтын хугацаа баримтлаагүй, гэмтэлтэй багажаар тоололт авах, үзлэг үйлчилгээ, тохируулга хийгээгүй, усалгааны технологи баримтлаагүй тохиолдол бүр...г.м) - 2%
- Сарын дунгэрэг ажиглалт, хэмжил гологдол болсон тохиолдол бүрд -10%
- Үүл, үзэгдэл, түүний эрчимшил, алсын барааны харагдац, хөрсний гадаргын байдал, цасан бүрхүүлийн ажиглалт гэх мэт нүдэн баримжааны ажиглалт буруу ажигласныг засаагүй тохиолдол бүр (ажиглалт хоорондын хугацааны үзэгдэл, салхины өөрчлөлтийг ажиглаагүй бол үүнд хамаарна) – 1%
- Дүгнэх журмыг баримтлаагүй тохиолдол бүрд -1%

### 2.1.2 Нарны цацраг судлалын шинжилгээний ажил

Нарны цацраг судлалын шинжилгээний ажлын чанарыг

- мэдээний ирц
- шүүмж шалгалт гэсэн 2 үзүүлэлтийн дунджаар дүгнэнэ.

#### 2.1.2.1 Мэдээний ирц

Эх мэдээг хугацаанд нь дамжуулсан бол 100% гэж дүгнэх ба тайлан мэдээ хоцроосон тохиолдол бүрд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Цахим мэдээг сар бурийн 5-ны дотор ирүүлэх бөгөөд хугацаа хоцроосон бол хоног тутамд - 2%
- Хүний буруугаас шалтгаалж мэдээ тасарсан хоног тутамд – 2% (тог тасралт, автомат станцын гэмтэл зэргийг тооцохгүй, автомат станц хэвийн ажиллагаатай боловч тохируулгыг буруу хийнээс шалтгаалан тасарсан мэдээ, эх мэдээг устгасан зэрэг)
- Жилд 1 сараас илүү хугацаагаар мэдээ тасалсан тохиолдолд тасарсан сар тутамд – 20% хасна.

**Тайлбар:** Багажийн баталгаажуулалт хийлгэхдээ аль болох сар дамнуулахгүй байх. Автомат станц эвдэрсэн бол сарын дотор арга хэмжээ авч хэвийн ажиллагаанд оруулах.

- Автомат станцын баталгаажуулалт хийгдсэний дараа цацрагийн мэдээлэл (нийлбэр цацраг, шулуун цацраг, ойсон цацраг, цацрагийн баланс) бүрэн бичигдэж байгаа эсэхэд хяналт тавиагүй улмаас аль нэг цацраг тасарсан хоног тутамд -3%
- Автомат станцын баталгаажуулалт хийгдсэний дараа цацрагийн мэдээлэл (дэлгэцэн дээр тоололт гарч ирж байгаа ч гэсэн лог файл дээр нийлбэр цацраг, шулуун цацраг, ойсон цацраг, цацрагийн баланс) бүрэн бичигдэж байгаа эсэхэд хяналт тавиагүй улмаас аль нэг цацраг тасарсан хоног тутамд -3%

#### 2.1.2.2 Шүүмж шалгалт

Нарны цацраг судлалын мэдээний формат нэгэн төрлийн бол 100% гэж дүгнэж, дараах байдлаар хувь хорогдуулна. Үүнд:

- Автомат станцын мэдээний протокол ирүүлээгүй бол – 5%

- Автомат станцын мэдээний протокол дутуу хөтөлсөн бол (тасалдлын буртгэл хийгээгүй, тасарсан шалтгаан бичээгүй, автомат станцын ажиллагааны талаар тайлбар, тэмдэглэл дутуу хөтөлсөн) – 2%
- Автомат станцын мэдээний форматыг нэгэн төрлийн болгоогүй бол (буруу log үүсгэсэн, log файлын нэр, он сар, өдөр, цаг, хугацааны дараалал гэх мэт) – 5%
- Log файлаас зөв .isx /эх мэдээ/ үүсгээгүй болон дутуу .isx (эх мэдээ) үүсгэсэн бол -3%
- Программын тохицуулга буруу хийсэн тохиолдолд – 2%
- Нарны гийгууллийн үргэлжилсэн хугацааг буруу гаргасан тохиолдол бүрд -1%
- Буруу зассан тохиолдол бүрд – 1%
- Хүрээлэнгийн холбогдох нэгжээс өгсөн зөвлөмж, зааврыг анхан шатны нэгжид зөвлөн хэрэгжүүлээгүйгээс алдааг 2 дахь сардаа давтаж ирүүлбэл -2%, 3 дахь сардаа давтвал -3% гэх мэт хувь ноогдуулж хасна.
- Холбогдох нэгжээс өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгээгүй болон тайлбар хүргүүлээгүй бол -2%

### **2.1.3 Аэрологийн шинжилгээний ажлын чанар**

Аэрологийн шинжилгээний ажлыг:

- хөтөлбөрийн биелэлт
- мэдээний ирц
- шүүмж шалгалтын чанар гэсэн 3 үзүүлэлтээр сар бүр дүгнэнэ.

#### **2.1.3.1 Хөтөлбөрийн биелэлт**

Хөтөлбөрийн дагуу радиозондыг бүрэн хөөргөж олон улсын солилцоонд мэдээг гаргасан бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Зонд хөөргөлтийн хөтөлбөрийн биелэлтийг дүгнэхдээ бодит хөөргөлтийн тоог сар жилийн хөтөлбөрт заасан тоонд харьцуулж тооцно.

**Тайлбар:** Техникийн гэмтэл , хөөргөлтийн үед (7-9, 19-21 цаг) хийн генераторын хаалга руу чиглэсэн 16 м/с, түүнээс дээш хурдтай салхитай, дуу цахилгаантай аадар бороотой нөхцөлд хөөргөлт хийгээгүй бол хувь хорогдуулахгүй.

- Хүний буруутай үйл ажиллагаанас болж ажиглалт хийгээгүй өөрөөр хэлбэл 500 гПа –ын гадарга хүрэлгүй мэдээ тасарсан тохиолдолд давтан хөөргөлтийг цаг тухайд нь (7-9, 19-21 цаг) зааварчилгааны дагуу хийгээгүй бол -10%
- Хөөргөлтийн цагийг баримтлаагүй тохиолдолд /11.30, 23.30 цагт/- 1%
- Хөөргөлт үргэлжлүүлэх боломжтой тохиолдолд хөөргөлтийг үргэлжлүүлэхгүй зогсоосон бол тохиолдол бүрээс 5%-иар тооцож хасна.

#### **2.1.3.2 Мэдээний ирц**

Хөөргөлтийн багцалсан мэдээ алдаагүй бүрэн ирсэн бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Хөөргөлт хийсэн боловч ЗИП мэдээг дамжуулаагүй бол - 2%
- TEMP мэдээг олон улсын солилцоонд оруулаагүй бол - 5%
- Тухайн өдрийн хөөргөлтийн багцалсан /зип/ мэдээг дараа өдрийн 10 цагаас өмнө хүрээлэнгийн холбогдох хэлтэс дамжуулаагүй бол - 2%
- Сар тутмын хөөргөлтийн хүснэгт, материал боловсруулалтын цахим тайланг дараа сарын 5-ны дотор /дотоод сүлжээгээр хүрээлэнгийн холбогдох хэлтэст ирүүлээгүй бол хоцроосон хоног тутамд - 1%
- Мэдээний нэр өргөтгөл буруу, бүтэц алдаатай тохиолдол бүрд - 1%

#### **2.1.3.3 Шүүмж шалгалтын чанар**

Шүүмж шалгалтыг бүрэн чанартай хийсэн бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулан дүгнэнэ. Үүнд:

- Тухайн нэг хугацааны ажиглалт дутуу болон гологдол болсон бол - 10%
- Завсрын шим мандал, онцлог цэг, хүчтэй салхийг буруу тодорхойлсоныг илрүүлээгүй бол - 1%
- TEMP мэдээний алдаатай бүлэг бүрд- 1%
- АХ-10, 9, 6 хүснэгтүүдэд мэдээг алдаатай, буруу шивсэн тохиолдол бүрд- 1%
- Шаарны хийг тохицуулж хийлээгүй болон хүний буруутай үйл ажиллагаанаас дундаж өндөр авалтад хүрээгүй бол 1 км бүрд 1%-иар хасаж дүгнэнэ.

**Тайлбар:** (чанар муутай бөмбөлөг хөөргөснөөс дундаж өндөр 17 км-ээс бага болсон тухай тайлбар, тэмдэглэл хийсэн тохиолдолд хувь хасахгүй).

#### 2.1.4 Төвийн ачааллыг үнэлэх коэффициент

Аймаг, хотын нар, цаг уур, аэрологийн шинжилгээний ажлын ачааллыг үнэлэхдээ салбарын тоо болон хөтөлбөрийн биелэлтийн ачааллыг тооцож, нэмэлт оноо өгөх байдлаар дүгнэнэ.

$$\text{Ачааллын коэф} = \text{салбарын ачаалал} + x \backslash b \text{ ачаалал}$$

Энд: Салбарын ачааллыг тооцоходоо өртөө, харуулын тооноос гадна нарны цацраг судлал, аэрологийн салбар тус тус багтах ба 1 салбарт оногдох хөрвүүлэх үржвэр өртөөнд 0.02, харуулд 0.01 байна /нар, аэрологийн салбар өртөөтэй адил болно/.

$$\text{Салбарын ачаалал} = 0.02 * \text{өртөөний тоо} + 0.01 * \text{харуулын тоо} + 0.02 * \text{нар} + 0.02 * \text{аэрологи}$$

Хөтөлбөрийн биелэлтийн ачааллыг тооцоходоо тухайн өртөө, харуулын шинжилгээний ажлын батлагдсан хөтөлбөрийн биелэлт бүрэн хэрэгжиж байгаа бол хөрвүүлэх үржвэр 0.02-оор байна /нар, аэрологийн салбар адил болно/. Аль нэг ажиглалт тасарсан хөтөлбөр дутуу бол үүнд хамрагдахгүй.

$$x \backslash b \text{ ачаалал} = 0.02 * \text{өртөө, харуулын тоо} + 0.02 * \text{нар} + 0.02 * \text{аэрологи}$$

#### 2.2 ХӨДӨӨ АЖ АХУЙН ЦАГ УУР

ХААЦУ-ын хөтөлбөрт шинжилгээний ажлыг:

- мэдээний ирц
- хөтөлбөрийн биелэлт
- ажиглалтын мэдээний бүтэц
- ажиглалтын мэдээний чанар
- шүүмж шалгалт гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэнэ.

##### 2.2.1. Мэдээний ирц

Агродундаж мэдээг сар бүрийн 1, 11, 21-ний өдөр, Улаанбаатарын цагаар 12:00 цагт багтааж УЦУОСМХ-ийн ХААЦУСХ-т бүрэн ирүүлнэ.

Мэдээний ирцийг дүгнэхдээ коодын мэдээний бүлгийг тооцох ба хоцроосон бүлэг бүрээс 5%-ийг хасна. жишээ нь Коодын мэдээ нийт 12 бүлэгтэй бөгөөд 3 бүлэг мэдээг орхигдуулсан бол  $3*5\% = 15\%$  хасна.

##### 2.2.2. Хөтөлбөрийн биелэлт

Ажиглалтыг хөтөлбөр, технологийн дагуу бүрэн гүйцэд хийж, 10 хоногийн агродундаж мэдээнд коодолж өгнө. Хөтөлбөрийн биелэлтийг дүгнэхдээ тухайн салбарын ажиглалтын үзүүлэлт тус бүрээр дүгнэнэ. Үүнд:

- Тасалсан (шалтгаангүйгээр хийгээгүй) ажиглалт бүрээс 1% хорогдуулж бүлэг тус бүрээр ажиглалт хийгээгүй мэдээний хувийг гаргана. Хөтөлбөрийн биелэлтийг хувилж бодож гаргана. Өөрөөр хэлбэл, тасалсан ажиглалтын мэдээний нийлбэрийг нийт ирүүлсэн мэдээний тоонд хувааж 100-аар үржүүлэн 100%-иас хасаж хөтөлбөрийн биелэлтийн дүнг салбар бүрээр гаргана. Жишээлбэл, 811\_84 бүлэгт нийт 15 үзүүлэлтийг коодолж ирүүлэхээс 1 элементийг ирүүлээгүй бол  $100-1/15*100=93.3\%$  гэж тооцно.
- Тухайн салбар хөтөлбөрт ажлыг тасалсан буюу огт хийгээгүй бол 100% хасаж дүгнэнэ.
- Цаг уурын бүлгийн мэдээнд хөтөлбөрийн биелэлт дүгнэхгүй.

##### 2.2.3. Ажиглалтын мэдээний бүтэц

Агродундаж мэдээгээр ирсэн ХААЦУ-ын бүх төрлийн ажиглалтын мэдээнд бүтцийн шалгалтыг 10 хоног тутамд хийж, ажлыг салбар бүрээр дүгнэнэ.

Бүлэгт алдаатай коодолсон элемент тус бүрээс 1%-ийг хорогдуулж, алдаатай ирүүлсэн мэдээний тоог бүлэг тус бүрээр гаргана. Алдаатай мэдээний хувь хэмжээг мөн хувилж бодож аргаар, салбар бүрээр гаргана. Жишээлбэл, 800\_80 бүлэгт 14 элементийг коодолж ирүүлэхээс 1 элементийг буруу өгсөн бол  $100-1/14*100=92.9\%$  гэж тооцно.

##### 2.2.4. Ажиглалтын мэдээний чанар

Аймгийн инженерүүд агродундаж мэдээгээр ирсэн ХААЦУ-ын бүх төрлийн ажиглалтын мэдээг 3-4 хоногийн дотор шалгаж, эргэлзээтэй мэдээг өртөө, харуулаас лавлаж, шаардлагатай бол зураг, бичлэг авч шалган салбаруудын ажиглалтын чанарыг дүгнэнэ.

Ажиглалтын заавар, технологи баримтлаагүйгээс гаргасан алдаа тус бүрээс 10%-ийг хасна. Хэрвээ тухайн арав хоногт ажиглалтын чанарт алдаа гаргаж хасуулсан бол дараагийн ажиглалтын мэдээг баталгаажуулсан фотозураг болон ажиглалтын дэвтрийн зургийг авч төвд илгээнэ. Агродундаж мэдээгээр ирсэн болон ажиглалтын дэвтрийн мэдээ зөрвөл 2.2.3-ийг баримтлан дүгнэнэ.

### 2.2.5. Шүүмж шалгалт

ХААЦУСХ-ийн инженерүүд харицсан аймгуудын ХААЦУ-ын бүх төрлийн мэдээг 2-3 хоногт багтаан шалгаж, хариу зааварчилгааг аймгуудад хүргүүлнэ.

Үүнд:

- Хөтөлбөрийн биелэлт тасалж, ажиглалт хийгээгүй илрүүлээгүй бол-10%
- Ажиглалтын технологи, заавар баримтлаагүйгээс гаргасан алдааг илрүүлээгүй бол үзүүлэлт тус бүрээр-10%
- Буруу зассан тохиолдол бүрт-5%
- Ажиглалтын хугацаа баримтлаагүйг илрүүлээгүй тохиолдол бүрт-3%-иар тус тус хувь хорогдуулж дүгнэнэ.

Тайлбар:

- ХААЦУ-ын мэдээллийн сангууд нь арав хоногийн агро дундаж мэдээгээр үүсэж, баяжигдаж байгаа тул шугам гэмтэлтэй, сүлжээ байхгүй байсан зэрэг тохиолдолд мэдээг заавал нөхөж ирүүлнэ.
- Ээлжийн амралттай болон хүндэтгэх шалтгааны улмаас мэдээ ирүүлээгүй бол ирцнээс хасаж тооцохгүй.
- Бэлчээрийн төлөв байдлын (ХД-8), МААЦУ-ын (ХД-3), өвлүүн явуул судалгааны (ХХ-26), бэлчээрийн даацын, ган зудын зэрэг бусад мэдээллийн сангууд төрөлжсөн сан хэлбэртэй хуучнаараа баяжигдаж явна.
- Салбаруудаас ирсэн агродундаж мэдээг аймгийн ХААЦУ-ын инженерүүд сар бурийн 1, 11, 21-ний өдөр, Улаанбаатарын цагаар 12:00 цагт багтааж шалгаж алдааг зассан байна.

## 2.3 УС СУДЛАЛ

Ус судлалын хөтөлбөрт шинжилгээний жилийн ажлын дүнг:

- хөтөлбөрийн биелэлт
- шинжилгээний ажлын чанар
- урсац бодолт
- мэдээний ирц гэсэн 4 үзүүлэлтийн дунджаар дүгнэнэ.

### 2.3.1 Хөтөлбөрийн биелэлт

Хөтөлбөрийн биелэлтийг сар бурийн /УХШ-1/ дүнгийн дунджаар гаргана. Ус судлалын харуулд ажиглалтыг хөтөлбөрийн дагуу бүрэн хийсэн бол биелэлт 100%, ажиглалт тасарсан бол дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Аль нэг хугацааны усны түвшин, булингар, газар доорх ус, булгийн ажиглалт тасарсан тохиолдол бүрд- 3 %
- Ус, хагшаасны өнгөрөлт хэмжилт тасарсан бол тухайн сард хэмжих нийт өнгөрөлтийн тооноос хувиар тооцож хасна. Усны түвшний өөрчлөлт бага уед илүү хэмжсэн өнгөрөлтэд хувь нэмэхгүй, харин дулааны улиралд усны түвшин ихсэх, буурах, хавар, намрын зааг уед хэмжсэн нэмэлт өнгөрөлт тутам + 5%
- Халиа, тошин, ууршил зэрэг төлөвлөгөөт ажиглалтыг тасалсан тохиолдол бүр -10%
- Гулдрилын 2-3 хэв шинжийг агуулаагүй, ажиглалтын хэсгийн уртыг зөв сонгоогүй, гулдрилын хэв гажилтын зураглал хийгээгүй тохиолдол бүрд - 5 %
- Өмнөх жилийн зурагтай харьцуулах боломжгүй, орчны өөрчлөлтийн талаарх нарийвчилсан тайлбар ирүүлээгүй, сонгож авсан хэв шинжүүдийг нарийвчилж тодорхойлоогүй тус бүрд - 2%

Местлийн хээрийн хэмжилт судалгааг төвөөс тогтоож өгсөн төлөвлөгөөний дагуу бүрэн явуулсан бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулж жилийн дүнд орууна. Үүнд:

- Явуул судалгааны тоог шалтгаангүйгээр цөөрүүлсэн бол тухайн жилийн 1 удаагийн явуул судалгаанд оногдох хувиар тооцох,
- Хээрийн хэмжилт, судалгааны хүрээнд шаардлагатай шонгуудыг суулгаагүй, хэмжилтийг хийгээгүй бол тухайн шон тус бүрд ногдох хувиар тооцох,
- Явуул судалгааны хүрээнд хяналтын өнгөрөлт, нийлбэр тунадас хэмжээгүй бол 1 өнгөрөлт, нийлбэр тунадас хэмжилтэд ногдох хувиар тооцох,

- Тухайн жилийн судалгаа эхлэх өдрийг шалтгаангүйгээр оройтуулсан, эрт дуусгасан бол хоног тутамд - 2%

### **2.3.2 Шинжилгээний ажлын чанар**

Ажлын чанарыг:

- усны түвшин хэмжэгийн чанар
- түвшин өнгөрөлтийн хамаарлын хувь
- алдааны хувь гэсэн 3 үзүүлэлтийн дунджаар дүгнэнэ.

- Нивелирдлэг, зэрэгцээ тоололт, шонгийн хөдөлгөөнөөс үүдэлтэй түвшний алдааг илрүүлээгүй тохиолдол - 10%
- Хамаарлын хувь: Усны түвшний хэлбэлзлийг хамруулж өнгөрөлт хэмжиж чадсан эсэхийг үнэлнэ. Харин 1 дүгээр зэргийн харуул үерийн түвшнээс давж, хэмжих боломжгүй үед хамаарлын хувийг 80%-иас их бол 100% гэж тооцно.
- Алдааны хувийг хяналтын муруйн жилийн алдаагаар дүгнэнэ. Хэмжсэн өнгөрөлт олон жилийн өнгөрөлтийн муруйгаас 15%-иас их хазайсан тохиолдол бүрд - 5%
- Бэхжүүлэх уусмалын концентрацыг бага найруулснаас шалтгаалан сорыц муудсан тохиолдол бүрд - 5%
- Мөстлийн хайлалтын мэдээг бүрэн боловсруулаагүй, шонгын дугаар зөрүүлсэн тохиолдол бүрд- 5%

### **2.3.3 Урсац бодолт**

Урсац бодолтыг өмнөх оны эмхтгэл бүрдүүлсэн байдлаар дүгнэж, илэрсэн алдааг дараах хувиар хорогдуулж тооцно. Үүнд:

- Шүүмж шалгалт: Түвшний шалтгаангүй огцом өөрчлөлт, муруйгаас хазайсан цэгийн шалтгаан, хавар, намрын заагийг зөв тогтоогоогүй, ус, агаарын температур, месний үзэгдэл, зузаан, усны түвшин, хур тунадас зэрэг элементийн явц зөрчилтэй гэх мэт алдааг илрүүлээгүй тохиолдол бүр - 1%
- Алдаа(G)-г УХ-2А хүснэгтийн гол чөлөөтэй үеийн бүх өнгөрөлтөөр бодож, зөвшөөрөгдөх тооноос илүү /8 өнгөрөлт тутамд 1/ гологдол өнгөрөлт хассан тохиолдол бүрд - 1%
- Муруйг өмнөх оны болон олон жилийн дундаж муруйтай уялдуулаагүй, үндэслэлтүйгээр хамаарлын муруйг хандлагаар татсан бол - 5%
- Хамаарлын хувь: Усны түвшний хэлбэлзлийг хамруулж өнгөрөлт хэмжиж чадсан эсэхийг үнэлнэ. Харин 1 дүгээр зэргийн харуул үертэй хэмжих боломжгүй үед хамаарлын хувь 80% -иас их бол 100% гэж тооцно.
- Тухайн оны хамгийн их түвшинд өнгөрөлт хэмжих боломжгүй үед тооцооны аргаар их түвшний өнгөрөлтийг тооцсон тохиолдол бүрд + 1%
- Шалган туслахаар явсан тохиолдолд хөндлөн зүсэлтийн талбай, хяналтын өнгөрөлтийг тооцож муруй дээр тэмдэглээгүй тохиолдол бүр – 3%
- Өмнөх оны хурд, талбай, өнгөрөлтийг хатгаагүй тохиолдол бүр – 3%

### **2.3.4 Мэдээний ирц**

Сарын мэдээний ирцийг дор дурьдсан үзүүлэлтээр дүгнэнэ. Үүнд:

- УХШ-1 мэдээний ирц тогтоосон хугацаанаас хоцроосон хоног тутамд - 2%
- Тогтмол мэдээний ирцийг /уерийн болон аюул мэдээ/ шалтгаангүйгээр 10 цагаас оройтсон тохиолдолд тухайн мэдээнд ноогдох хувиар тооцож хасна.
- Сорыц хоцроосон хоног тутамд -1%
- Гулдиралын зураглал хийх ажлыг 6, 9 дүгээр сард 20-ны дотор ирүүлээгүй хоцорсон хоног тутамд -1%
- Өмнөх оны урсацыг тухайн оны 4 дүгээр сарын 1-ний дотор ирүүлээгүй тохиолдолд хоцорсон хоног тутамд -1%

## **2.4 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЧАНАР**

Байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори дүгнэнэ. Шинжилгээний ажлын чанарыг чухалчилж үзэх ба энэ нь нийт авбал зохих онооны 60%, хөтөлбөрийн биелэлтийг 30%, мэдээний ирц 10%-иар тус тус хувь тэнцүүлэн дүгнэнэ.

Байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг

- хөтөлбөрийн биелэлт
- ажлын чанар
- шинжилгээний мэдээний ирц гэсэн 3 үзүүлэлтийн дунджаар улирал бүрийн дараа сарын 10-ны дотор багтаан дүгнэнэ.

#### **2.4.1. Хөтөлбөрийн биелэлт**

Агаар, ус, тунадас тоосонцор, хөрсний шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу хийсэн бол 100 хувь, бусад тохиолдолд дараах байдлаар хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Шинжилгээний ажлыг шалтгаангүйгээр тасалсан бол – 5%
- Тодорхойлох үзүүлэлтийг тодорхойлоогүй бол – 5%

**Тайлбар:** Багаж, тоног төхөөрөмж эвдэрсэн, бодис дууссан, цахилгаан тасарсан, усны сорьц авах боломжгүй буюу ёроолдож хөлдсэн, тог тасарсан, сургалт, семинарт оролцсон, зэлжийн ажилтангүй зэрэг тодорхой шалтгааны улмаас тасарсан тохиолдолд хөтөлбөрийн биелэлтээс хасахгүй.

#### **2.4.2. Ажлын чанар**

Ажлын чанарыг үнэлэхэд тухайн жилд хийгдсэн лаборатори хоорондын харьцуулсан чанарын хяналтын дүн, мэдээллийн санд оруулсан дүнгийн чанарыг шалгуур болгоно.

Агаар, ус, хөрс, тунадас тоосонцрын сорьц авч, шинжилгээний ажлын арга, аргачлалыг мөрдөж ажилласан бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хорогдуулж дүгнэнэ.

- Ажиглалт, шинжилгээний ажлыг хуурамчаар хийсэн нь тогтоогдвол – 5%
- Жишиг тахирмаг, уусмалын нормаль концентрацыг хугацаанд нь шинэчлэн тогтоогоогүй бол үзүүлэлт бүрээр – 2%
- Урвалж уусмалыг буруу бэлтгэсэн, багажийн ажиллагааг шалгаагүй, шинжилгээний ажлыг буруу гүйцэтгэсэн нь тогтоогдсон бол – 10%
- Хөрс, усны сорьцыг бохир сав, баглаа боодолд илгээсэн тухай бүрд - 2%
- Сорьц дагалдах хуудасгүй, дутуу, буруу бөглөж ирүүлсэн тохиолдол бүрд – 1%
- Шинжилгээний дүнг мэдээллийн санд алдаатай оруулсан нь тогтоогдсон, түүнийг хугацаанд нь засварлаагүй бол -5%
- Чанарын хяналтын стандарт сорьцод хийсэн шинжилгээний үр дүн нь бодит утгаас ±15хувиас зөрсөн бол үзүүлэлт бүрд 1 хувь, ±30 %-иас зөрсөн бол үзүүлэлт бүрд - 2%

#### **2.4.3 Мэдээний ирц**

Агаар, ус, хөрс, тунадас тоосонцрын шинжилгээний дүн мэдээг хугацаанд нь бүрэн дамжуулсан бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хорогдуулж дүгнэнэ.

- Шинжилгээний дүн мэдээг холбогдох журмын дагуу хугацаанд нь ирүүлээгүй бол - 5%
- Чанарын хяналтын стандарт сорьцын шинжилгээний дүнг хугацаанд нь ирүүлээгүй бол - 1%

### **2.5 ХЭМЖИЛ ЗҮЙ, ТЕХНОЛОГИЙН МӨРДӨЛТИЙН ЧАНАР**

Ус цаг уур, орчны шинжилгээний хэмжилзүйн ажлыг:

- багажийн баталгаажуулалт
- багажийн тохируулга үйлчилгээний чанар гэсэн 2 үзүүлэлтийн дунджаар дүгнэнэ.

Тухайн жилд хийх багажийн баталгаажуулалтын ажлын төлөвлөгөөг оны эхэнд аймаг бүрээр гаргуулж батлан мөрдүүлнэ. Төлөвлөгөөний дагуу хэмжлийн багажуудыг шалгалаа тохируулгын ажилтан шалгаж материалыг БОХЗТЛ-д ирүүлнэ. Шаардлага хангасан хэмжлийн үр дүнг Улсын шалгагч баталгаажуулна. Тухайн аймагт шалгалтын багаж байхгүй тохиолдолд төвд ирүүлж шалгуулах, хэмжлийн үр дүнд дүгнэлт хийж хэмжилд ашиглаж болох эсэхийг тогтоож ашиглах арга хэмжээ авна.

#### **2.5.1 Багажийн баталгаажуулалт**

Багажийн баталгаажуулалтыг хэдэн хэмжих хэрэгслийг баталгаажуулсныг үндэслэн хувиар дүгнэнэ. Баталгаажуулах хэмжих хэрэгсэлд стандарт мөрдөөгүй, эсхүл хэмжлийн үр дүнд хийсэн дүгнэлтийг буруу хийсэн бол тэр багажийг баталгаажуулахгүй. Энэ тухай хэмжил зүйн улсын шалгагчийн дүгнэлтийг БОХЗТЛ-иас хүргүүлнэ.

#### **2.5.2 Багажийн тохируулга үйлчилгээ**

Цаг уурын автомат станц, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа тасралтгүй байдлыг 80% хангасан бол хэвийн гэж үзэх болон хэмжлийн багажийн тохируулга үйлчилгээг сайн хийж өртөө, харуулд ашиглаж буй хэмжлийн багажийн тохируулга, гэмтлээс шалтгаалсан алдаа гологдол гараагүй бол 100% гэж дүгнэх ба алдаа гарсан тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулан дүгнэнэ. Үүнд:

- Үйлчилгээ хийгээгүйгээс тэмдэглүүр багажийн даралт тохироогүй, хүрд гацах, мэдрэх чадваргүй болсон /спирт, мөнгөн ус тасарсан, ус мэдрэмжгүй болсон/ хэмжих хэрэгсэл, багаж ашиглаж буй өртөө, харуул бүрээр – 1%

- Ажлын эталон хэмжих хэрэгсэлүүдийг хөтөлбөрийн дагуу баталгаажуулалтанд хамруулаагүй болон хугацаа хоцроосон – 5%
- Цаг уурын автомат станцууд, хэмжих хэрэгсэлийг хөтөлбөрийн дагуу баталгаажуулалтанд хамруулаагүй тохиолдол бурд – 1%
- Цаг уурын автомат станцууд, хэмжих хэрэгсэлийг баталгаажуулалтанд хамруулсан ч аль нэг элементэд гарсан үл тохирол, түүнийг шалган хэмжлийн эргэлзээг үл арилгасан бол – 2%
- Хэмжих хэрэгсэлүүдийн сэлбэг хангaltaас үл шалтгаалан гарсан эвдрэл гэмтлийг оношилон засварлаагүйгээс мэдээ тасарсан хоног тутамд – 1%

## 2.6 МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ АЖЛЫН ЧАНАР

Мэдээлэл солилцооны ажлын чанарыг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор багтаан УЦУОСМХ-ийн холбоо, мэдээлэл солилцооны асуудал хариуцсан нэгж дүгнэнэ.

Мэдээлэл солилцооны ажлыг

- Мэдээ дамжуулалт /MD/
- Мэдээ солилцооны чанар
- Сүлжээ ашиглалт /SA/
- Тоног төхөөрөмжийн бэлэн байдал гэсэн 4 үзүүлэлтийн дунджаар дүгнэнэ.

### 2.6.1 Мэдээ дамжуулалт

Мэдээ дамжуулалтын ирцийг дараах үзүүлэлтээр тооцож дүгнэнэ

$$MD = \frac{n}{N} 100%; \quad MD = \frac{1}{K} \left( \sum_{i=1}^{i=k} \frac{n_i}{N_i} \times 100\% \right);$$

$MD$  – мэдээ дамжуулалт, хувиар илэрхийлсэн дүн

$N$  – дамжуулбал зохих мэдээний нийт тоо

$n$  – хугацаандаа дамжуулсан мэдээний тоо  
(тасарсан ба хоцорсон мэдээг хасаад)

Энд:

$K$  – дамжуулбал зохих мэдээний төрөл, погода, ААМО, климат, аргодундаж дамжуулдаг 4 төрлийн мэдээний нийт тоо  $/\Sigma - g$  гаргах болно.

$i$  – дамжуулбал зохих мэдээний төрөл  $i = 1, 2, 3, \dots, k$  байна.

- Мэдээг шалтгаангүйгээр хоцроосон, тасарсан тохиолдолд бурд -5%  
(Өдөр бүр хянааад, Сард 1 удаа дүгнэнэ)

### 2.6.2 Мэдээ солилцооны чанар

Ажиглалтын мэдээ дамжуулалтыг цаг уурын шинжилгээний өртөөд өдөр бүрийн 23, 02, 05, 08, 11, 14, 17, 20 цагийн ажиглалтын хугацааны дараах 10 минут, олон улсын солилцоонд гардаг мэдээг 15 минут, цаг уурын шинжилгээний харуулзууд өдөр бүрийн 08, 14, 20 цагийн ажиглалтыг 30 минутын дотор тус тус алдаагүй хугацаандаа дамжуулсан бол 100 %, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Алдаатай мэдээ дамжуулсан бол -1% /алдаагаа хугацаандаа засаж дамжуулсан бол хувь хасахгүй/
- АК-01 коод мэдээ дамжууллын "Анхааруулга" болон "Алдаа"-нд гарсан мэдээллийг шалгаж тайлбар бичээгүй бол – 1%
- "Алдаа"-тай мэдээг засаагүй 1 цаг тутамд – 1% эсвэл 1 өдөрт – 5%
- Тасарсан ажиглалтын мэдээг нөхөж оруулаагүй 1 өдөрт – 5% /өдрийн мэдээг 08-20 цаг, шөнийн мэдээг 20 цагаас дараа өглөөний 08 цагийн хооронд дахин засварлаж дамжуулсан бол давхардуулж оноо хасахгүй/.

**Тайлбар:** Мэдээг ажиглагчийн буруугаас биш хоцроосон, тасарсан шалтгааныг 24 цагийн дотор ээлжийн синоптик инженер болон холбоо, мэдээллийн технологи хариуцсан инженер оруулна.

Мэдээлэл дамжуулах вебэд сууринласан системийн үр дүнг үндэслэн дүгнэнэ. Мэдээ солилцооны чанарт ЦУОШГ-ын Улсын сүлжээний асуудал хариуцсан нэгж давхар хяналт тавьж, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

### 2.6.3 Сүлжээ ашиглалт

Сүлжээ ашиглалтыг хувиар дүгнэнэ.

$$SA = \frac{1}{K} \left( \sum_{i=1}^{i=k} \frac{n_i}{N_i} \times 100\% \right); 1 \text{ сүлжээтэй бол } SA = \frac{n}{N} 100\%; \text{ болно.}$$

Энд:

$SA$  – сүлжээ ашиглалт, хувиар илэрхийлсэн дүн.  $k$  – сүлжээний төрөл.

$N$  – ашиглавал зохих үндсэн сүлжээний ажиллах цаг,  $n$  – ажилласан цаг

#### 2.6.4 Тоног төхөөрөмжийн бэлэн байдал

Мэдээлэл үйлчилгээний ажилд ашигладаг нийт тоног төхөөрөмжийг ажилд бэлэн байлгасан байдал, үйлчилгээг тогтмол хийж байнгын бэлэн байдал, тасралтгүй ажиллагааг хангасан байдлаар дүгнэнэ. Бэлэн байгаагүй тохиолдлын тоог хасаж тооцно.

$$\text{Ганц } TT - \text{ той бол } TT\text{ББ} = \frac{n}{N} \times 100\%; \quad \text{олон } TT \text{ байдаг бол } TT\text{ББ} = \frac{1}{K} \left( \sum_{i=1}^{i=k} \frac{n_i}{N_i} \times 100\% \right)$$

TTББ – тоног төхөөрөмжийн бэлэн байдал /ашиглалт/, хувиар илэрхийлсэн дүн

Энд:

$N$  – TT-ийн бэлэн байх тохиолдлын тоо /хоног/,  $n$ -ажилд бэлэн байсан тохиолдлын тоо /тасарсан, saatcnyig хасаад/.

$i$  - ашиглавал зохих нийт TT-ийн төрөл,  $1=1, 2, 3, \dots$ , к байна.

$K$  - ашиглавал зохих нийт TT-ийн төрөл, интернет, УЗАТ, телефон утас, гар утас ашигладаг бол 4 байна. 4 төрлийн TT-ийн ажилд бэлэн байх тохиолдлын тооны нийлбэрээр гаргана. Үндсэн ба нөөцийн тоног төхөөрөмж гэж ялган дүгнэж болно.

### 2.7. ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Цаг агаарын урьдчилсан мэдээний ажлыг:

- нарийвчилсан, хоног болон 5 хоногийн урьдчилсан мэдээний ирц
- нарийвчилсан, хоног болон 5 хоногийн урьдчилсан мэдээний таарц
- цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн урьдчилан мэдээний таарц, онч
- аюул-агаар мэдээний ирц, чанар
- климат мэдээний ирц, чанар
- нэгдсэн хэлэлцүүлгийн ирц гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэнэ

#### 2.7.1. Нарийвчилсан, хоног болон 5 хоногийн урьдчилсан мэдээний ирц

Нарийвчилсан мэдээг өглөө 08:30 цагаас өмнө, хоногийн мэдээг өдөр 14:00 цаг, 5 хоногийн мэдээг 16 цагаас өмнө гаргаж ЦУОШГ-ын төв сервер [/http://192.168.100.30/](http://192.168.100.30/) хуудсанд, хоногийн болон нарийвчилсан сэргэмжлүүлгээ мэдээ, урьдчилан сэргийлэх мэдээ, аюул агаар мэдээг <http://alarm.tsag-agaaar.gov.mn> хуудсанд тавьж үйлчилнэ. Мэдээг хоцроосон тохиолдолд дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

- Хүндэтгэх шалтгаангүйгээр хугацаанаас хоцроосон тохиолдолд - 5 оноо
- Тодорхой шалтгааны улмаас /цахилгааны болон сүлжээний saatcnyig/ хоцроосон бол 2 оноо хасаж дүгнэнэ.

Урьдчилсан мэдээний ирцийг дараах байдлаар дүгнэнэ.

- Хоног болон 5 хоногийн нарийвчилсан урьдчилсан мэдээ цаг хугацаандaa бүрэн ирсэн бол 100% гэж дүгнэх бөгөөд хоцроосон тохиолдолд дараах хувиар хорогдуулж дүгнэнэ.
- Хоногийн урьдчилсан мэдээ тухайн өдрийн 14.00 цагаас хойш, нарийвчилсан мэдээ өглөө 08.30 цагаас хойш, 5 хоногийн урьдчилсан мэдээ 16.00 цагаас хойш ирсэн бол тасарсанд тооцох бөгөөд тасарсан тохиолдол бүрд - 5%

#### 2.7.2. Нарийвчилсан, хоног болон 5 хоногийн урьдчилсан мэдээний таарц

Урьдчилсан мэдээний таарцыг:

- агаарын температур
- салхи
- хур тунадас гэсэн үзүүлэлтээр дүгнэж дундажлана.

#### 2.7.2.1 Агаарын температурын урьдчилсан мэдээний таарц

Агаарын температурын урьдчилсан мэдээний таарцыг хүснэгт 1-ийн дагуу дүгнэнэ.

Хүснэгт 1. Агаарын температурын урьдчилсан мэдээний таарц

Бодит байдалд ажиглагдсан температур ба урьдчилсан мэдээнд өгсөн температурын зөрөө	Таарц /хувь/
3°C ба түүнээс бага	100
4°C ба түүнээс их	0

Жишээ нь: Урьдчилсан мэдээнд агаарын хамгийн их температурыг 25°C гэж өгсөн үед бодит байдалд ажиглагдсан температур нь 22-28°C бол таарц 100 %, 21°C ба түүнээс бага эсвэл 29°C ба түүнээс их бол 0 % гэж дүгнэнэ.

#### 2.7.2.2. Салхины урьдчилсан мэдээний таарц

Салхины урьдчилсан мэдээний таарцыг хүснэгт 2-ын дагуу дүгнэнэ.

Хүснэгт 2. Салхины урьдчилсан мэдээний таарц

Өдөр, шөнийн салхины зонхилох бодит хурд, урьдчилсан мэдээний салхины хурдны утгын зөрүү	Таарц /хувь/
3 м/с ба түүнээс бага	100
4-5 м/с ба тэнцүү	50
6 м/с ба түүнээс их	0

Салхины хурдны урьдчилсан мэдээг бодит байдалд ажиглагдсан зонхилох их хурдтай харьцуулан дүгнэнэ. Салхины чиглэл болон өрөвхийллийн хурдыг дүгнэхгүй.

Жишээ нь, Урьдчилсан мэдээнд салхины зонхилох хурдыг 7 м/с гэж өгсөн үед бодит утга нь 4 м/с байвал урьдчилсан мэдээний таарц нь 100%, 2-3 м/с байвал таарц нь 50%, 1 м/с байвал таарц нь 0% болно.

#### 2.7.2.3 Хур тунадасны урьдчилсан мэдээний таарц

Хур тунадасны урьдчилсан мэдээний таарцыг шингэн болон хатуу хур тунадасны мэдээний таарцаар дүгнэнэ.

#### 2.7.2.3 a/ Шингэн тунадасны урьдчилсан мэдээний таарц

Шингэн тунадасны урьдчилсан мэдээний таарцыг хүснэгт 3-ыг баримтлан дүгнэнэ.

Хүснэгт 3. Шингэн тунадасны мэдээний таарц

Мэдээнд хэрэглэсэн хэллэг, нэр томъёо	12/1 цагт орсон хур тунадасны хэмжээ, /мм/				
	Ороогүй	0.0-1.4	1.5-29.0	30.0-49.0	≥50
Бороо орохгүй, Хур тунадасгүй	100	0	0	0	0
Бага зэргийн бороо /60/ Бага зэргийн аадар /80,81/ Дуу цахилгаантай бага зэргийн аадар /90,91/ Ялимгүй хур тунадас /27,28/	0	100	50	0	0
Бороо /61/, Аадар бороо /82,83/ Дуу цахилгаантай аадар бороо /92,93/ Хур тунадас /65/	0	50	100	50	0
Их бороо /62/ Усархаг аадар бороо /84,85/ Дуу цахилгаантай усархаг аадар бороо /94,95/ Их хур тунадас, нойтон цас /66/	0	0	50	100	50
Их усархаг бороо /63/ Усархаг ширүүн аадар бороо /86,87/ Дуу цахилгаантай усархаг ширүүн Аадар бороо /96,97/ Аадар их хур тунадас /67/	0	0	0	50	100

Тайлбар: Дуу цахилгаантай бага зэргийн аадар орно гэж өгсөн үед ажиглалтын хугацаанд 16,17-гоор, ажиглалтын хугацааны хооронд 9-өөр коодлогдох үзэгдэл ажиглагдсан тохиолдолд 50хувь гэж авна. Аадар бороо / дуу цахилгаантай аадар бороо орно гэж өгсөн үед хэмжээний хувьд таарсан ч, 4 цагаас илүү хугацаагаар үргэлжилсэн үед 75% гэж дүгнэнэ.

Бороо /хур тунадас/ орохгүй гэж өгсөн үед 0.0 мм бороо /хур тунадас/ орсон бол таарцыг 100% гэж дүгнэнэ.

### 2.7.2.3 б/ Хатуу хур тунадасны урьдчилсан мэдээний таарц

Хатуу хур тунадасны урьдчилсан мэдээний таарцыг хүснэгт 4-ийг баримтлан дүгнэнэ.

#### Хүснэгт 4. Хатуу хур тунадасны мэдээний таарц

Мэдээнд хэрэглэсэн хэллэг, нэр томъёо	12 цагт орсон хур тунадасны хэмжээ, мм				
	Ороогүй	0.0-0.1	0.1-4.0	5.0-9.0	≥10.0
Цас орохгүй	100	50	0	0	0
Ялимгүй цас /23,24/	50	100	50	0	0
Цас /71/	0	50	100	50	0
Их цас орно /73/	0	0	50	100	50
Аадар их цас орно /75/	0	0	0	50	100

Тайлбар: Цан, хяруунаас хур тунадас хэмжсэн тохиолдлыг тунадас орсон гэж тооцохгүй.

### 2.7.3 Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийг урьдчилан мэдээлсэн байдал

Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийг:

- сэргийлэлэх мэдээ /СМ/ болон урьдчилан сэргийлэх мэдээ /УСМ/-ний таарц, онч
- цаг агаарын аюултай үзэгдэл /AY/ болон гамшигт үзэгдэл /GY/
- цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийг урьдчилан илрүүлсэн хувь гэсэн 3 үзүүлэлтээр дүгнэнэ.

#### 2.7.3.1 Сэргийлэлэх мэдээ болон урьдчилан сэргийлэх мэдээ

Сэргийлэлэх мэдээ, урьдчилан сэргийлэх мэдээг хүснэгт 5-д заасан, АМ-г ЦУОШГ-ын 2015 оны А/155 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн гаргана. АМ-г дүгнэхгүй.

Сэргийлэлэх мэдээ болон урьдчилан сэргийлэх мэдээг өгсөн үед аюултай үзэгдэл болон гамшигт үзэгдлийн эрч хүч, үргэлжлэх хугацаа, хамрах газар нутаг нь хүснэгт 3, 4-т заасан хэмжээнд хүрсэн эсэхээс хамааран 100%, 50%, 0% гэж гаргах бөгөөд хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, цочир хүйтрэлтийн СМ-ний таарцыг тус бүрээр ялгаварт (дифференциаль) аргаар доорх томьёогоор дүгнэнэ.

$$P = \frac{n_{100} * 100 + n_{50} * 50}{N + n_+}$$

Энд:  
 N- СМ зарласан нийт өртөө, харуулын тоо  
 n<sub>100</sub>- 100%-ийн таарцтай өртөө, харуулын тоо  
 n<sub>50</sub>- 50%-ийн таарцтай өртөө, харуулын тоо  
 N+- СМ зарлаагүй байхад AY ажиглагдсан өртөө, харуулын тоо

Хүснэгт 5. Сэргийлэлэх болон Урьдчилан сэргийлэх мэдээ зарлах нөхцөл (ЗГ-ын 2015 оны 286 дугаар тогтооолын 2 дугаар хавсралт)

№	Үзэгдлийн нэр, ангилал	Аюултай үзэгдэл	Үргэлжлэх хугацаа	Гамшигт үзэгдэл	Үргэлжлэх хугацаа
1	Хүчтэй салхи	Салхины дундаж хурд 18м/с түүнээс их (өрөөхийлөлт 24м/с түүнээс их)	Хугацаа хамаарахгүй	Салхины дундаж хурд ойт хээр, уулархаг нутагт 24м/с, тал хээр, гоөв, цөлийн бүсэд 28м/с түүнээс их (өрөөхийлөлт 34м/с түүнээс их)	Хугацаа хамаарахгүй
2	Цасан шуурга	Салхины дундаж хурд 10м/с түүнээс их үед цасан шуурга шуурч алсын бараа 2000 м ба түүнээс бага	3 цаг ба түүнээс дээш	Салхины дундаж хурд 16м/с түүнээс их (өрөөхийлөлт 24м/с түүнээс их) үед цасан шуурга шуурч алсын бараа 2000 м ба түүнээс бага болох	6 цаг ба түүнээс дээш
3	Шороон шуурга	Алсын бараа 1000 м ба түүнээс бага	3 цаг ба түүнээс дээш	Алсын бараа 50 м ба түүнээс бага	6 цаг ба түүнээс дээш

4	Бороо	30.0мм ба түүнээс их	12 цаг ба түүнээс бага	50.0мм ба түүнээс их	12 цаг ба түүнээс бага
5	Цас, нойтон цас (IX.10-IV.10)	5.0мм ба түүнээс их	12 цаг ба түүнээс бага	10.0мм ба түүнээс их	12 цаг ба түүнээс бага
6	Аадар бороо	30.0мм ба түүнээс их	3 цаг ба түүнээс бага	30.0мм ба түүнээс их	1 цаг ба түүнээс бага
7	Мөндөр	Голч нь 10 мм ба түүнээс бага	Хугацаа хамаарахгүй	Голч нь 10 мм ба түүнээс их	Хугацаа хамаарахгүй
8	Хүйтэн бороо (Мал ноосолсон ўеэр)	Агаарын дундаж температур 9-11°C, салхины дундаж хурд 6м/с ба түүнээс их	12 цаг ба түүнээс дээш	Агаарын дундаж температур 8°C ба түүнээс бага, салхины дундаж хурд 6м/с болон түүнээс их үед 5.0мм-ээс их бороо үргэлжлэн орох	12 цаг ба түүнээс дээш
9	Усны үер	Гол, мөрний ус үерийн түвшинд хүрэх	Хугацаа хамаарахгүй	Гол, мөрний ус эргээсээ хальж аюултай түвшинд хүрэх	Хугацаа хамаарахгүй
10	Цочир хүйтрэл (Тарьмалын ургалтын хугацаанд)	Хөрсний гадаргын температур 0°C ба түүнээс бага	Хугацаа хамаарахгүй	Хөрсний гадаргын температур -5°C ба түүнээс бага	Хугацаа хамаарахгүй
11	Уруйн үер			Хүчтэй аадар борооны ус гуу жалга, хэвгий даган шавар, шороо чулуутай холилдож хүйлран урсах	Хугацаа хамаарахгүй
12	Догшин хуй (Хар салхи)			Хүчтэй хөгжсөн борооны бөөн үүлнээс үүлэн багана унжиж замд таарсан бүхнийг сорон авах, зөвдэн сүйтгэх. Хэдэн арван километер зурваасаар сүйтгэл учруулна.	Хугацаа хамаарахгүй
13	Аянга			Хүчтэй хөгжсөн борооны бөөн үүл болон газар хооронд ниргэлт явагдах үзэгдэл	Хугацаа хамаарахгүй

- Их бороо, их цас, нойтон цас, хүйтэн борооны СМ, УСМ-ний таарц, ончийг хүснэгт 5, 6-аар, аадар бороо, аянга, мөндөр, догшин хуй гэсэн үзэгдлүүдийн СМ, УСМ-г хүснэгт 7-г баримтлан тус тус дүгнэнэ.
- СМ-нд хүчтэй салхи, цасан шуурга гэх мэт 2 ба түүнээс дээш тооны АҮ болох тухай мэдээлсэн үед 2 тусдаа СМ гэж үзэж таарцыг үзэгдэл тус бүрээр дүгнэнэ.
- УСМ-нд хүчтэй салхи, шороон шуурга гэх мэт 2 ба түүнээс дээш тооны ГҮ болох тухай мэдээлсэн үед аль нэг үзэгдэл нь ГҮ-ийн хэмжээнд хүрсэн бол УСМ-ний таарцыг 100% гэж дүгнэнэ.
- СМ, УСМ-ний үйлчлэх хугацааг "өнөө шөнө, маргааш" гэж зааж өгсөн үед уг СМ, УСМ-г 2 тусдаа СМ, УСМ гэж тооцон тус тусад нь таарцыг дүгнэнэ.
- СМ, УСМ гаргаагүй үед эрч хүч, хамрах газар нутгийн хувьд АҮ, ГҮ-ийн хэмжээнд хүрсэн үзэгдэл ажиглагдсан бол "өгөөгүй ажиглагдсан" өөрөөр хэлбэл урьдчилан мэдээлж чадаагүй АҮ, ГҮ гэнэ. Урьдчилан мэдээлж чадаагүй АҮ, ГҮ-ийг хоног, хагас хоног, хэт богино хугацааны урьдчилсан мэдээний аль алинд нь хамааруулж дүгнэнэ.
- СМ, УСМ өгсөн үед тухайн үзэгдлийн эрч хүч, хамрах газар нутгийн хувь нь АҮ, ГҮ-ийн хэмжээнд хүрээгүй буюу таарц нь 30%-иас бага бол "хуурамч түгшүүр" гэнэ. Хуурамч түгшүүрийг мөн хоног, хагас хоног, хэт богино хугацааны урьдчилсан мэдээний аль алинд нь хамааруулж дүгнэнэ.

- Хоногийн мэдээнд СМ, УСМ өгсөн хэдий ч тухайн АҮ, ГҮ болно гэж үзсэн хэвээр бол маргааш өглөө нь нарийвчилсан мэдээнд СМ, УСМ-г заавал өгнө. Хоногийн мэдээнд СМ, УСМ өгөөд нарийвчилсан мэдээнд СМ, УСМ өгөөгүй үед АҮ, ГҮ болсон бол мэдээг нарийвчлахдаа тухайн АҮ, ГҮ болохгүй гэж тооцоолсон гэж үзээд нарийвчилсан СМ, УСМ-ын таарц, ончийг 0 хувь гэж авна. Мөн хоногийн мэдээнд СМ, УСМ өгөөгүй, нарийвчилсан мэдээнд СМ, УСМ өгсөн үед АҮ, ГҮ болсон бол АҮ, ГҮ-ийг хоногийн өмнөөс мэдээлээгүй гэж үзэн хоногийн СМ, УСМ-ний таарц, ончийг 0 % гэж авна.
- Өгөөгүй ажиглагдсан АҮ-ийг хүснэгт 6-г баримтлан тогтооно.
- ГҮ-ийн хувьд хамрах нутаг дэвсгэрийн нэгжийн 1 өртөө, харуулд ГҮ ажиглагдсан бол тухайн үзэгдлийг ажиглагдсан гэж үзнэ. Харин хүчтэй салхины УСМ өгөөгүй үед Ховд, Говь-Алтай, Өмнөговь аймгийн хувьд 2 буюу түүнээс дээш өртөө, харуулд ГҮ ажиглагдсан үед ГҮ ажиглагдсан гэж үзнэ.
- АҮ, ГҮ тухайн өртөө, харуул дээр ажиглагдаагүй боловч өртөө, харуулын харьялах нутаг дэвсгэрт хүний амь нас эрсдсэн, эсвэл эд материалын их хэмжээний хохирол учирсан, үзэгдлийн эрч хүчний тухай мэдээлэл албан ёсоор холбогдох газруудад ирсэн бол тухайн өртөө, харуул дээр АҮ (ГҮ) ажиглагдсан гэж үзнэ.
- Цочир хүйтрэлтийг тогтвортой 3 хоног дулаарсны дараа агаар болон хөрсөн дээр 0 градус ба түүнээс доош орох үед СМ, УСМ өгнө.
- Цочир хүйтрэлт 1-ээс олон хоног тухайн бүс нутагт ажиглагдах бол анхааруулах мэдээнд үргэлжлэх хугацааг зааж өгнө (энэ хугацаанд СМ, УСМ дахиж өгөхгүй)
- Тухайн бүс нутгаас өөр бүс нутагт эсвэл эрч хүч нэмэгдэх нөхцөл бүрдвэл СМ болон УСМ өгч болно.

**Жишээ нь:** Орхон аймаг “Эрдэнэт хотод хүчтэй салхи болно” гэсэн СМ өгсөн үед эрдэнэт өртөөн дээр хүчтэй салхи ажиглагдаагүй боловч ажиглалтын сүлжээгүй ойролцоо нутагт хүчтэй салхи болж, хохирлын мэдээлэл төө орон нутгийн цаг уурын байгууллага, Онцгой байдлын хэлтэс, газарт ирсэн бол Эрдэнэт хотод хүчтэй салхины АҮ ажиглагдсан гэж үзнэ.

**Хүснэгт 6. СМ өгөөгүй үед АҮ ажиглагдвал “өгөөгүй ажиглагдсан” гэж тооцох газар нутгийн хувь**

Нутгийн 20 хувь-д	Нутгийн 30 хувь-д
Цасан шуурга	Хүчтэй салхи
Их бороо	Шороон шуурга
Их цас, нойтон цас	Хүйтэн бороо
Аадар бороо	Цочир хүйтрэл

- УСМ өгсөн үед таарц, ончийг хүснэгт 8, 10-г баримтлан дүгнэнэ.
- УСМ өгөөгүй, СМ өгсөн үед ГҮ ажиглагдсан тохиолдолд СМ-ний таарц, ончийг 50% гэж дүгнэнэ. Мөн СМ өгөөгүй, УСМ өгсөн үед АҮ ажиглагдсан тохиолдолд УСМ-ний таарц, ончийг 50% гэж дүгнэнэ.
- Нутгийн 20%, 30% хувьд хамруулах өртөө, харуулын тоог Хүснэгт 12-д үзүүлснээр авна.

**Хүснэгт 7. Хүчтэй салхи, шороон шуурга, цочир хүйтрэлт, цасан шуурганы СМ-ний таарц**

Цаг агаарын үзэгдэл	Дүгнэх үзүүлэлт	Таарц		
		100 хувь	50 хувь	0 хувь
Хүчтэй салхи	Дундаж их хурд, өрөвхийлэлт	Дундаж их хурд, 15-27м/c, өрөвхийлэлт 24-33м/c	Дундаж их хурд 12-14м/c эсвэл өрөвхийлэлт 15-23м/c, *1 - Дундаж их хурд 28м/c ба түүнээс их эсвэл өрөвхийлэлт 34м/c ба түүнээс их	Салхины дундаж их хурд 11 м/c-ээс бага, эсвэл СМ өгөөгүй үед нутгийн 30хувь-аас их газарт дундаж их хурд 18 м/c ба түүнээс их, өрөвхийлэлт 24 м/c ба түүнээс их болох
Цасан шуурга	Цасан шуурга үргэлжилсэн хугацаа,	Салхины хурд 10-15 м/c байхад Цасан шуурга, орон шуурга 1 цаг,	Салхины хурд 8-9 м/c байхад цасан шуурга шуурах, цасан шуурга 1 цагаас бага	Цасан шуурга болоогүй, эсвэл СМ өгөөгүй үед нутгийн 20 хувиас их газарт 10-15 м/c салхитай

	салхины хурд,	түүнээс дээш хугацаагаар үргэлжлэх	хугацаагаар үргэлжлэх	цасан шуурга 1 цагаас их хугацаагаар шуурах
Шороон шуурга	Шороон шуурга үргэлжилсэн хугацаа,	Шороон болон элсэн шуурга 1 цаг ба түүнээс их хугацацаагаар үргэлжлэх	Шороон шуурга 1 цагаас бага хугацаагаар үргэлжлэх, алсаас зөөгдсөн шороо тоос ажиглагдсан	Шороон шуурга болоогүй, эсвэл СМ өгөөгүй үед нутгийн 30 хувиас их газарт шороон шуурга 1 цагаас их хугацаагаар шуурах
Цочир хүйтрэл	Хөрсний гадаргын температур	Хөрсний гадаргын температур 0°C ба түүнээс бага	-	Хөрсний гадаргын температур 0.6 градус ба түүнээс дулаан

- Цасан шуурганы СМ: Шөнийн хугацаанд цас орж, салхины дундаж их хурд 10-15 м/с хүрсэн бол цасан шуурганы таарцыг 100%, 8-9 м/с эсвэл 16 м/с ба түүнээс давж салхилсан бол таарцыг 50% гэж дүгнэнэ.
- Шороон шуурганы СМ: Шөнийн хугацаанд салхины дундаж их хурд 15-27 м/с, өрөвхийлэлт 24-33 м/с хүрсэн бол таарцыг 100%, 12-14 м/с, өрөвхийлэлт 15-23 м/с, дундаж их хурд 28 м/с ба түүнээс их эсвэл өрөвхийлэлт 34 м/с ба түүнээс их болсон бол таарцыг 50% гэж дүгнэнэ.
- Өдрийн хугацаанд шороон шуурганы аюул ирээгүй үед ажиглалтын хугацаанд шороон шуурга ажиглагдаж, салхины дундаж их хурд 15-23 м/с хүрсэн бол таарцыг 100%, 12-14 м/с эсвэл 24 м/с ба түүнээс давж салхилсан бол таарцыг 50% гэж дүгнэнэ.

#### 2.7.3.2. Цаг агаарын аюултай үзэгдэл /AY/ болон гамшигт үзэгдэл /GY/

Цаг агаарын аюултай үзэгдэл /AY/ болон гамшигт үзэгдэл /GY/-ийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8. Хүчтэй салхи, шороон шуурга, цочир хүйтрэл, цасан шуурганы УСМ-ний таарц

Цаг агаарын үзэгдэл	Дүгнэх үзүүлэлт	Таарц, Онч		
		100 %	50 %	0 %
Хүчтэй салхи	Дундаж их хурд, өрөвхийлэлт	GY болно гэж өгсөн нутгийн өртөө харуулын аль нэгд нь салхины дундаж их хурд ойт хээр, уулархаг нутагт 24м/с ба түүнээс их, тал хээр, говь, цөлийн бүсэд 28м/с ба түүнээс их өрөвхийлэлт 34 м/с ба түүнээс их хүрсэн байх	GY болно гэж өгсөн нутгийн 30-аас их хувьд салхины дундаж их хурд, 15-27м/с, өрөвхийлэлт 24-33 м/с хүрсэн байх.	Дундаж их хурд 15 м/с-ээс бага, өрөвхийлэлт 24 м/с -ээс бага, УСМ өгөөгүй үед аймгийн өртөө, харуулын нэгд дундаж их хурд 28 м/с ба түүнээс их, өрөвхийлэлт 34 м/с ба түүнээс их болсон бол
Хүчтэй цасан шуурга	Цасан шуурганы үргэлжилсэн хугацаа салхины дундаж их хурд,	GY болно гэж өгсөн нутгийн өртөө харуулын аль нэгд нь салхины хурд 16 м/с ба түүнээс их болж цасан шуурга 6 цаг түүнээс удаан хугацаагаар үргэлжлэх	GY болно гэж өгсөн нутгийн 20-иос их хувьд салхины хурд 10-15 м/с, цасан шуурга 1 цагаас их, 6 цагаас бага хугацаагаар үргэлжлэх	Цасан шуурга болоогүй, цасан шуурга 1 цагаас бага хугацаагаар үргэлжилсэн, УСМ өгөөгүй байхад аймгийн өртөө, харуулын нэгд хүчтэй цасан шуурганы GY болсон бол
Хүчтэй шороон шуурга	Шороон шуурганы үргэлжилсэн хугацаа, алсын барааны харагдац	Шороон болон элсэн шуурга шуурч, алсын барааны харагдац 50м-ээс бага болж 6 цаг ба түүнээс их хугацаагаар үргэлжлэх	Шороон болон элсэн шуурга шуурч, алсын барааны харагдац 50м-ээс их 1 цаг ба түүнээс их хугацаагаар үргэлжлэх	Шороон шуурга болоогүй, шороон шуурга 1 цагаас бага хугацаагаар үргэлжилсэн, УСМ өгөөгүй байхад аймгийн өртөө, харуулын нэгд хүчтэй шороон шуурганы GY болсон бол

Цочир хүйтрэл	Хөрсний гадаргын температур	ГҮ болно гэж өгсөн нутгийн өртөө харуулын аль нэгд нь хөрсний гадаргын температур $-5^{\circ}\text{C}$ ба түүнээс бага болох		Хөрсний гадаргын температур $-4.6^{\circ}\text{C}$ ба түүнээс дулаан эсвэл УСМ өгөөгүй үед аль нэг өртөө харуулд цочир хүйтрэлийн ГҮ болсон бол
---------------	-----------------------------	--	--	---

- Дулааны бургианы гаралтай нөөлөг салхинд хамаарахгүй, зөвхөн фронтын гаралтай хүчтэй салхины СМ, УСМ дүгнэхэд баримтална.
- Цасан шуурганы УСМ: Шөнийн хугацаанд ГҮ болно гэж өгсөн нутгийн өртөө харуулын аль нэгд нь цас орж, салхины дундаж их хурд 16 м/с ба түүнээс их бол таарцыг 100%, ГҮ болно гэж өгсөн нутгийн 20%-иас их хувьд нь салхины хурд 10-15 м/с бол таарцыг 50 % гэж дүгнэнэ.
- Хүчтэй шороон шуурганы УСМ: Шөнийн хугацаанд салхины дундаж их хурд ГҮ болно гэж өгсөн нутгийн өртөө харуулын аль нэгд нь салхины дундаж их хурд ойт хээр, уулархаг нутагт 24м/с ба түүнээс их, тал хээр, говь, цөлийн бүсэд 28 м/с ба түүнээс их өрөвхийлэлт 34 м/с ба түүнээс их хүрсэн бол шороон шуурганы таарцыг 100%, нутгийн 30%-иас их хувьд салхины дундаж их хурд 15-27 м/с, өрөвхийлэлт 24-33 м/с хүрсэн бол таарцыг 50% гэж дүгнэнэ.
- \*<sup>1</sup> - Ховд, Говь-Алтай, Өмнөговь аймгуудын хувьд энэ нөхцлийг зөвхөн СМ өгсөн үед 1 өртөө, харуулд ГҮ ажиглагдсан бол ашиглана.

Хүснэгт 9. Их бороо, их цас, нойтон цас, хүйтэн борооны СМ-ний таарц, онч

Цаг агаарын үзэгдэл	Дүгнэх үзүүлэлт	Таарц, Онч		
		100 %	50 %	0 %
Их бороо	Тунадасны хэмжээ, хамрах газар нутаг	AY болно гэж өгсөн нутгийн ядаж 1 өртөө харуулд 30.0 мм түүнээс их бороо орсон, эсвэл АY болно гэж өгсөн нутгийн 20 ба дүүнээс дээш хувьд 15.0 мм ба түүнээс их бороо орсон	AY болно гэж өгсөн нутгийн ядаж 1 өртөө харуулд 15.0 мм түүнээс их бороо орсон, эсвэл нутгийн 20-иос их хувьд 10.0-14.0 мм бороо орох.	AY болно гэж өгсөн нутгийн 20-иос бага хувьд нь 14.0 мм-ээс бага бороо орсон эсвэл СМ өгөөгүй байхад нутгийн 20-иос дээш хувьд 30.0 мм ба түүнээс их бороо орсон
Их цас, нойтон цас (IX.10-IV.10)	Тунадасны хэмжээ, хамрах газар нутаг	AY болно гэж өгсөн нутгийн 20 ба түүнээс дээш хувьд 5.0 мм ба түүнээс их цас орсон	AY болно гэж өгсөн нутгийн ядаж 1 өртөө харуулд 5.0 мм ба түүнээс их цас орсон, эсвэл СМ өгсөн нутгийн 20-иос их хувьд 3-4 мм цас орох.	AY болно гэж өгсөн нутгийн 20-иос бага хувьд нь 4.0 мм-ээс бага цас орсон, эсвэл СМ өгөөгүй байхад нутгийн 20 ба түүнээс их хувьд 5.0 мм ба түүнээс их цас орсон
Хүйтэн бороо (6, 7 сард )	Агаарын дундаж температур, салхины дундаж хурд, үргэлжилсэн хугацаа, хамрах газар нутаг	AY болно гэж өгсөн нутгийн 30 ба дүүнээс дээш хувьд агаарын дундаж температур $11^{\circ}\text{C}$ ба түүнээс бага, салхины дундаж хурд 6 м/с ба түүнээс их үед бороо 8 цаг түүнээс их хугацаагаар үргэлжлэх эсвэл нутгийн 30-иос их хувьд хүйтэн бороо 5-7 цаг үргэлжлэх, эсвэл СМ өгөөгүй байхад нутгийн 30 ба түүнээс их хувьд хүйтэн бороо 8 цагаас их хугацаагаар үргэлжлэн орох	AY болно гэж өгсөн нутгийн ядаж 1 өртөө харуулд агаарын дундаж температур $11^{\circ}\text{C}$ ба түүнээс бага, салхины дундаж хурд 6м/с ба түүнээс их үед бороо 8 цаг түүнээс их хугацаагаар үргэлжлэх эсвэл нутгийн 30-иос их хувьд хүйтэн бороо 5-7 цаг үргэлжлэх	AY болно гэж өгсөн нутгийн 30-аас бага хувьд нь хүйтэн бороо 5-7 цаг үргэлжлэх, эсвэл СМ өгөөгүй байхад нутгийн 30 ба түүнээс их хувьд хүйтэн бороо 8 цагаас их хугацаагаар үргэлжлэн орох

Хүснэгт 10. Их бороо, их цас, нойтон цас, хүйтэн борооны УСМ-ний таарц, онч

Цаг агаарын үзэгдэл	Дүгнэх үзүүлэлт	Таарц, Онч		
		100 %	50 %	0 %
Их бороо	Тунадасны хэмжээ, хамрах газар нутаг	ГҮ болно гэж өгсөн өртөө харуулын нэгд нь 50.0 мм ба түүнээс их бороо орох	ГҮ болно гэж өгсөн нутгийн 20-иос их хувьд 15.0-49.0 мм бороо орсон	Нутгийн 20-иос бага хувьд 15.0-49.0 мм бороо орох. Мөн УСМ өгөөгүй байхад аймгийн өртөө, харуулын нэгд их борооны ГҮ болсон
Их цас, Нойтон цас (IX.10-IV.10)	Тунадасны хэмжээ, хамрах газар нутаг	ГҮ болно гэж өгсөн өртөө харуул харуулын нэгд нь 10.0 мм ба түүнээс их цас орсон	ГҮ болно гэж өгсөн нутгийн 20-иос их хувьд 5.0-9.0 мм цас орсон	Нутгийн 20-иос бага хувьд 5.0-9.0 мм цас орох. Мөн УСМ өгөөгүй байхад аймгийн өртөө, харуулын нэгд их цасны ГҮ болсон
Хүйтэн бороо (6, 7 сард )	Агаарын дундаж температур, салхины дундаж хурд, үргэлжилсэн хугацаа, тунадасны хэмжээ, хамрах газар нутаг	ГҮ болно гэж өгсөн өртөө харуулын нэгд агаарын дундаж температур 8°C ба түүнээс бага, салхины дундаж хурд 6 м/с ба түүнээс их үед 5.0 мм-ээс их бороо 8 цаг түүнээс их хугацаагаар үргэлжлэх	ГҮ болно гэж өгсөн нутгийн 30-аас их хувьд агаарын дундаж температур 9-11°C, салхины дундаж хурд 6м/с ба түүнээс их үед бороо 8 цаг түүнээс их хугацаагаар үргэлжлэх	ГҮ болно гэж өгсөн нутгийн 30-иос бага хувьд АҮ болох, эсвэл агаарын дундаж температур 12°C ба түүнээс их, болон салхины дундаж хурд 5м/с ба түүнээс бага үед бороо 8 цаг түүнээс их хугацаагаар үргэлжлэх

Хүснэгт 11. Аадар бороо, аянга, мөндөр, догшин хуй гэсэн үзэгдлүүдийн СМ, УСМ-ний таарц, онч

Цаг агаарын үзэгдэл	Дүгнэх үзүүлэлт	Таарц, Онч		
		100%	50%	0%
<b>СМ</b>				
Аадар бороо	Тунадасны хэмжээ, үргэлжилсэн хугацаа, өртөө харуулын тоо	АҮ болно гэж өгсөн өртөө харуулын нэгд нь 3 цагийн дотор 30.0 мм ба түүнээс их бороо орсон	АҮ болно гэж өгсөн нутгийн өртөө харуулын нэгд нь 3 цагийн дотор 15.0-29.0 мм бороо орох, эсвэл 15.0 мм ба түүнээс их бороо 3 цагаас дээш хугацаанд орсон	15.0мм ба түүнээс их бороо огт ороогүй, Мөн СМ өгөөгүй байхад нутгийн 20-иос их хувьд 30.0мм ба түүнээс их аадар бороо орох
Мөндөр	Голч /мм/	АҮ болно гэж өгсөн өртөө харуулын нэгд нь мөндөр орсон	Аадар бороо орсон	Аадар бороо болон мөндөр ороогүй
<b>УСМ</b>				
Аадар бороо	Тунадасны хэмжээ, үргэлжилсэн хугацаа, өртөө харуулын тоо	ГҮ болно гэж өгсөн өртөө харуулын нэгд нь 1 цагийн дотор 30.0 мм ба түүнээс их аадар бороо орсон	ГҮ болно гэж өгсөн нутгийн өртөө харуулын нэгд нь 1 цагийн дотор 15.0-30.0 мм аадар бороо орсон эсвэл 15.0 мм ба түүнээс их аадар бороо 1	15.0 мм ба түүнээс их аадар бороо огт ороогүй, Мөн УСМ өгөөгүй байхад аймгийн өртөө, харуулын нэгд

			цагаас дээш хугацаанд орсон	аадар борооны ГҮ болсон
Мөндөр	Голч /мм/	ГҮ болно гэж өгсөн өртөө харуулын нэгд 10 мм ба түүнээс их голчтой мөндөр орсон	ГҮ болно гэж өгсөн өртөө харуулын нэгд 9 мм ба түүнээс бага голчтой мөндөр орсон	Мөндөр ороогүй
Догшин хуй	Хүчтэй хөгжсөн борооны бөөн үүлний суuriас газар хуртэл үүлэн багана үүсэх	Цаг уурын өртөө харуул дээр, өртөө харуулаас хол ч ажиглагчийн харааны газар, мөн өртөө харуулгүй хөдөө газар иргэдийн ам мэдээгээр догшин хуй болсон тухай мэдээ ирэх	Нөөлөг салхи ажиглагдсан	Догшин хуй болон нөөлөг болоогүй
Аянга	Борооны бөөн үүл ба газар хооронд ниргэлэг болох	Цаг уурын өртөө харуул дээр, өртөө харуулаас хол ч ажиглагчийн харааны газар, мөн өртөө харуулгүй хөдөө газар иргэдийн ам мэдээгээр аянга буусан тухай мэдээ ирэх		Аянга буугаагүй

**Тайлбар:** Радаргүй нутгуудад (одоогоор бүх аймгууд) аадар бороо, аянга, мөндөр, догшин хуй зэрэг үзэгдлүүдээр СМ болон УСМ гаргаагүй ч албан мэдээнд дуу цахилгаантай түр зуурын бороо, борооны өмнөх салхины ширүүсэл өгсөн бол өгөөгүй ажиглагдсан АҮ гэж үзэхгүй.

#### Хүснэгт 12. Нутгийн 20%, 30% гэж тооцох өртөө харуулын тоо

Нутгийн 20%		Нутгийн 30%	
Нийт өртөө, харуулын тоо	Ажиглагдсан өртөө, харуулын тоо	Нийт өртөө, харуулын тоо	Ажиглагдсан өртөө, харуулын тоо
1-6	1	1-4	1
7-12	2	5-8	2
13-17	3	9-11	3
18-22	4	12-14	4
23-27	5	15-18	5
28-32	6	19-21	6
		22-24	7
		25-28	8
		29-31	9

- СМ, УСМ-нд хэллэг нэр, томьёоны алдаа гаргасан тохиолдолд таарцыг 1%
- СМ, УСМ-г ЦУОШГ-ийн серверт байршуулахдаа хугацаа хоцроосон тохиолдолд СМ, УСМ-ний таарцаас хоцроосон 10 минут тутамд 1%-иар бууруулж дүгнэнэ.
- Хүчтэй салхи, шороон шуурга, цочир хүйтрэл, цасан шуурга гэсэн үзэгдлүүдийн СМ-ний онч нь АҮ тухайн аймгийн нийт хэдэн өртөө, харуулд ажиглагдсанаас хэдийг нь 100% таарцтай урьдчилан мэдээлж чадсаныг илэрхийлнэ. Харин УСМ-ний онч нь таарцтай адил дүгнэгдэнэ.

$$P_0 = \frac{n_{100} * 100}{(n_{100} + n_+)}$$

Энд:  $P_0$ -онч,

$n_{100}$  -Урьдчилан мэдээлж чадсан АҮ, ГҮ буюу 100%-ийн таарцтай өртөө, харуулын тоо;

$n_+$ -Урьдчилан мэдээ өгөөгүй боловч АҮ, ГҮ ажиглагдсан өртөө, харуулын тоо

Жишээ нь, А аймаг 9 өртөө, харуулд хүйтэн бороо орно гэж СМ өгсөнөөс 5 суманд таарц 100 % буюу хүйтэн бороо орж, СМ өгөгүй өөр 2 суманд хүйтэн бороо орсон бол ончийг  $5*100 / (5+2) = 71.4\%$  гэж дүгнэнэ.

- Их бороо, их цас, аадар бороо, хүйтэн борооны СМ, УСМ-ний онч нь таарцыг дүгнэсэнтэй адиллаар дүгнэгдэнэ. Мөндөр, догшин хуй, аянга зэрэг үзэгдлүүдээр зохиосон СМ, УСМ-ний ончийг дүгнэхгүй.
- Тухайн сард (тухайн аймгийн нутагт) хэдэн АҮ, ГҮ болсноос хэдийг нь 30%-иас дээш таарцтай урьдчилан мэдээлж чадсан болохыг хувиар илэрхийлж гаргасныг АҮ, ГҮ-ийг илрүүлсэн хувь гэнэ.

#### **2.7.3.3. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийг урьдчилан илрүүлсэн хувь**

Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийг урьдчилан илрүүлсэн хувийг дараах байдлаар тодорхойлно.

$$P_{\%} = \frac{(XCM_{30\% < \text{таарцтай}} + HCM_{30\% < \text{таарцтай}} + XUCM_{30\% < \text{таарцтай}} + HUCM_{30\% < \text{таарцтай}}) * 100}{(OA + XT)}$$

Энд:

- $P_{\%}$  - АҮ болон ГҮ-ийг илрүүлсэн хувь,
- $XCM_{30\% < \text{таарцтай}}$  – 30%-иас их дээш таарцтай хоногийн СМ-ний тоо,
- $HCM_{30\% < \text{таарцтай}}$  – 30%-иас их дээш таарцтай нарийвчилсан СМ-ний тоо,
- $XUCM_{30\% < \text{таарцтай}}$  – 30%-иас их дээш таарцтай хоногийн УСМ-ний тоо,
- $HUCM_{30\% < \text{таарцтай}}$  – 30%-иас их дээш таарцтай нарийвчилсан УСМ-ний тоо,
- ОА – өгөгүй ажиглагдсан АҮ, ГҮ-ийн тоо,
- ХТ-хуурамч түгшүүрийн тоо болно.

#### **2.7.4 Аюул агаар мэдээний ирц, чанар**

Аюул, агаар мэдээг:

- аюул агаар мэдээний ирц,
- аюул агаар мэдээний чанар гэсэн 2 үзүүлэлтийн дунджаар дүгнэнэ.

##### **2.7.4.1 Аюул, агаар мэдээний ирц**

Аюул, агаар мэдээг бүрэн илрүүлсэн бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Аюул, агаар мэдээг илрүүлээгүй тохиолдол бүрд – 5%
- Дутуу мэдээг серверт нөхөж оруулаагүй тохиолдол бүрд - 2%
- Алдаатай мэдээ засссан, дутуу мэдээг нөхөж оруулсан ч 1 хоногийн дотор илрүүлээгүй тохиолдол бүрд – 1% тус бүр хасаж дүгнэнэ

##### **2.7.4.2 Аюул агаар мэдээний чанар**

Аюул, агаар мэдээний чанарыг бүрэн алдаагүй бол 100%, бусад тохиолдолд дараах байдлаар хувь хорогдуулж дүгнэнэ. Үүнд:

- Аюул мэдээг хуурамчаар зохиосон, устгасан, эрч хүч, төрлийг өөрчилсөн тохиолдолд - 10%
- Мэдээнд алдаа гарсан тохиолдолд бүрд – 2% тус бүр хасаж дүгнэнэ.

#### **2.7.5 Климат мэдээний ирц, чанар**

Климат мэдээг:

- климат мэдээний ирц
- климат мэдээний чанар гэсэн 2 үзүүлэлтээр дүгнэнэ.

##### **2.7.5.1 Климат мэдээний ирц**

- климат мэдээ 14 цагаас өмнө хугацаанд ирсэн бол 100%, хугацаа хоцорч ирсэн тохиолдолд хоцорсон 1 цаг тутамд – 3%
  - климат мэдээ огт илрүүлээгүй тохиолдолд -100%
  - илрүүлсэн климат мэдээнд гарсан алдаа тутамд –3%
- гэж тус тус хорогдуулж дүгнэнэ.

### 2.7.5.2 Климат мэдээний чанар

Климат мэдээний чанарыг климат мэдээнд гарсан алдаа тутамд -3% хасаж дүгнэнэ.

## 2.8 НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Нисэхийн цаг уурын үйлчилгээний ажлын сарын дүнг:

- "Нислэгт үйлчилсэн цаг агаарын мэдээний чанар"
- "Нисэхийн цаг уурын үйлчилгээний ажлын ачаалал"-ын нийлбэрээр тооцон гаргана.

Нисэхийн цаг уурын үйлчилгээний хагас жил, жилийн дүнг сарын дүнгийн дунджаар тооцно.

### 2.8.1 Нислэгт үйлчилсэн цаг агаарын мэдээний чанар

Нислэгт үйлчилсэн цаг агаарын мэдээний чанарыг дараах үзүүлэлтүүдээр сар бүр дүгнэн дундажлан тооцно.

- A. Шуурхай үйлчилгээ
- B. Мэдээ зохиолт, дамжуулалтын чанар
- C. Шуурхай зохицуулалт
- D. Нисэх буудал орчмын урьдчилсан мэдээний таарц

№	Үзүүлэлт	Дүгнэх нөхцөл	Хасах хувь
A	Шуурхай үйлчилгээ	Урьдчилсан болон бодит мэдээг хоцроож дамжуулсан тохиолдол бүрээс	3
		Урьдчилсан болон бодит мэдээг огт дамжуулаагүй тохиолдол бүрээс	50
		Урьдчилсан мэдээ таараагүйгээс нислэгийн саатал гарсан, таараагүй мэдээний задлан судалгаа хийсэн тохиолдол бүрээс Жич: Задлан судалгааны ерөнхий дүгнэлт нь урьдчилан мэдээлэх боломжгүй гэж гарсныг НЦУТ-өөс хүлээн зөвшөөрсөн тохиолдолд оноо хасагдахгүй.	10
B	Мэдээ зохиолт	Урьдчилсан болон бодит мэдээ зохиолтын алдаа тус бүрээс	3
B	Шуурхай зохицуулалт	Шуурхай зохицуулалтын чиглэлээр гарсан тушаал, шийдвэр, үүрэг даалгавар биелүүлээгүй тохиолдол бүрээс	10
		Хэрэглэгч, харилцагч байгууллагаас гаргасан гомдол болон мэдээлэх хуудасны дагуу буруутай нь тогтоогдсон тохиолдол бүрээс	10
		НЦУТ-өөс сануулах болон шаардах хуудас авсан тохиолдол бүрээс	10
Г	Буудал орчмын урьдчилсан мэдээний таарц	Буудал орчмын урьдчилсан мэдээний сарын дундаж таарцыг ЦУОШГ, ИНЕГ-ын даргын хамтарсан тушаалаар баталсан "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам"-ыг баримтлан дүгнэнэ.	

### 2.8.2 Нисэхийн цаг уурын үйлчилгээний ажлын ачаалал

Нисэхийн цаг уурын үйлчилгээний ажлын ачааллыг үнэлэхдээ "Ачааллыг үнэлэх коэффициент"-ыг бодож тооцно. Ачааллыг үнэлэх коэффициентыг тооцоходоо үйлчилсэн нислэгийн тоо, зохиож дамжуулсан урьдчилсан болон бодит (TAF, TAF TOIM, METAR) мэдээний тоог үндэслэн нэмэлт оноо өгөх байдлаар дүгнэнэ.

$$\text{Ачааллын коэф} = 0.02 * \text{ундсэн нислэг} + 0.003 * \text{бэлтгэл нисэх буудал} \\ + 0.003 * (\text{TAF} + \text{TAF TOIM}) + 0.001 * (\text{METAR} + \text{SPECI})$$

Жич: Ачааллыг тооцоходоо тухайн сард үйлчилсэн үндсэн нислэг, бэлтгэл нисэх буудал, зохиож дамжуулсан урьдчилсан мэдээ ( $\text{TAF} + \text{TAF TOIM}$ ), бодит ажиглалтын мэдээ ( $\text{METAR} + \text{SPECI}$ )-ний тоог хөрвүүлэх үргээрээр үргүүлэн тооцно.

## 2.9 АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН ДЭД САН

Архив, мэдээллийн дэд сангийн ажлыг дараах үзүүлэлтүүдээр дүгнэнэ. Үүнд:

- Шинжилгээний архив
- Мэдээллийн дэд сан гэсэн 2 үзүүлэлтээр дүгнэнэ.

### **2.9.1 Шинжилгээний архив**

Шинжилгээний архивын ажлыг хүснэгт 1-ийн дагуу дүгнэнэ.

#### **Хүснэгт 1. Шинжилгээний архив**

<b>№</b>	<b>Ажлын үзүүлэлт</b>	<b>Хорогдуулах хувь /нийт 100%/ /</b>
1	Тухайн жилийн хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан ирүүлэх	Хугацаа хоцорсон хоног тутамд -10
2	Тухайн жилийн архивын баримтын нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг хянаж баталгаажуулан ирүүлэх	Хугацаа хоцорсон хоног тутамд -10
3	Улсын нэгдсэн дунд тоо мэдээг өмнөх оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гаргаж ирүүлэх	Хугацаа хоцорсон хоног тутамд -5, Алдаатай дун бүрээс -5
4	Тайлант хугацааны тайланг ирүүлэх	Хугацаа хоцорсон хоног тутамд -10
5	Архивын баримтын бүрдгэлийг шинэчлэн мэдээллийг ирүүлэх	Хугацаа хоцорсон хоног тутамд -5, Алдаатай дун бүрээс -5
6	Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, баримтын бурдгэлийг ирүүлэх	Хугацаа хоцорсон хоног тутамд -5
7	Хүлээн авсан баримтын дунг БНШК-ын хурлаар хэлэлцүүлж баталгаажуулсан тухай тэмдэглэл ирүүлэх	Хугацаа хоцорсон хоног тутамд -10
8	Статистик дүн, тайлан мэдээг гаргаж ирүүлэх /маягт-1, 2/	Хугацаа хоцорсон хоног тутамд -5 Алдаатай дун бүрээс -5
9	Архив хариуцсан ажилтан өөрчлөгдсэн тохиолдолд архивын бүх баримтад нэгдсэн тооллого хийж, ажлыг хүлээлцүүлж актыг ирүүлэх	Нэгдсэн тооллого хийж, акт ирүүлээгүй бол тухайн жилийн эцсийн дунгээс -25 оноо хасаж тооцно.
10	Баримтын дунг хэлэлцэхээс бусад асуудлаар БНШК-ын хурал зохион байгуулж тэмдэглэлийг ирүүлэх	Тэмдэглэл ирүүлсэн бол тухайн улирлын дун дээр +5 оноо нэмж тооцно.

### **2.9.2. Мэдээллийн дэд сан**

Мэдээллийн дэд сангийн ажлыг хүснэгт 2-ын дагуу дүгнэнэ.

#### **Хүснэгт 2. Мэдээллийн дэд сан**

<b>№</b>	<b>Ажлын үзүүлэлт</b>	<b>Хорогдуулах хувь /нийт 100%/ /</b>
1	Тухайн жилийн мэдээллийн дэд сангийн нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг хянаж баталгаажуулан ирүүлэх	Хугацаа хоцорсон хоног тутамд -10
2	Автомат станцын мэдээ сар бүр ирүүлэх	Хугацаа хоцроосон бол хоног тутамд -5 Мэдээ хүлээн авсан тухай акт ирүүлээгүй бол -10 Ирсэн мэдээний протокол дутуу бол станцын тоогоор -5 Ирсэн мэдээний станцын бүрдэл дутуу бол станцын тоогоор -5 Ирсэн мэдээний файл дутуу бол файлын тоогоор -5
3	Үүр амьсгалын горимын мэдээ /ISX, TAB, RES/ сар бүр ирүүлэх	Хугацаа хоцроосон бол хоног тутамд -5 Ирсэн мэдээний бүрдэл дутуу бол дутуу файлын тоогоор -5 Ирсэн мэдээ алдаатай бол алдаатай файлын тоогоор -5

### **Архив, мэдээллийн дэд сангийн жилийн дүнг нэгтгэх**

Архив, мэдээллийн дэд сангийн жилийн дүнг нэгтгэхдээ дараах үзүүлэлтуүдийг харгалзан үзнэ. Үүнд:

- Цаг үеийн шаардлага, тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгасан ажлын биелэлт, гүйцэтгэлийг тухайн тайлант хугацааны дунд оруулж тооцно.
- Архив болон мэдээллийн дэд сангийн ажлын үзүүлэлтуүдийг хариуцан гүйцэтгэх, үр дүнг хүлээлгэн өгөх хугацааг жил бүрийн хариу зааварчилгаа, зөвлөмжид дэлгэрэнгүй тусгах ба хүлээлгэн өгөх ёстой тухайн тайлант хугацааны дунд оруулан тооцно.
- Автомат станц болон уур амьсгалын горимын мэдээг тухайн оны нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх бөгөөд сар бүр мэдээний ирц, чанарыг дүгнэнэ.
- Архив болон мэдээллийн дэд сангийн дүнг нэгтгэж тус тусад нь тайлант хугацаагаар гаргана.
- Тус тусад нь гаргасан дүнгүүдийг нэгтгэж "Архив, мэдээллийн дэд сангийн жилийн нэгдсэн дүн"-г гаргана.

### **2.10. ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛЖ, ХУР ТУНАДАС НЭМЭГДҮҮЛЭХ АЖИЛ**

Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг:

- Удирдлага зохион байгуулалт, бэлэн байдлын хангалт
- Заавар, технологи мөрдөлт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа
- Ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн тайлан гэсэн үндсэн 3 үзүүлэлтээр дүгнэнэ.

#### **2.10.1. Удирдлага зохион байгуулалт, бэлэн байдлын хангалт**

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөхцөл байдал хүндрэх таримал болон бэлчээрийн ургамлын төлөв байдал доройтох, ган, хуурайшилт бий болох, ой хээрийн түймэр зэрэгт үнэлгээ хийж, хэрэгцээ шаардлага үүссэн үед синоптик процессыг алдсан, тооцоолж чадаагүй тохиолдол бүрд - 5%
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах бүрд үнэлгээ хийгээгүй, хуурамчаар хийсэн тохиолдол бүрд - 2%
- Экспедицэд ажиллах бүрэлдэхүүнийг чиг үүргийн дагуу орон тоог бүрэн ажилуулаагүй, эрхийн үнэмлэхгүй болон мэргэжлийн бус хүнийг ажиллуулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөөгүй тохиолдол бүрд - 2%
- Экспедицийн автомашин, техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн иж бүрдэл, ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангагдаагүй тохиолдолд бүрд -2%
- Экспедицийн бүрэлдэхүүний цалингийн нэмэгдэл, томилолт, гэнэтийн ослын даатгал, хамгаалах хэрэгслээр хангаагүй тохиолдолд бүрд -2%
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд орон нутгаас санхүүгийн дэмжлэг авсан тохиолдолд +2%-иар нэмэгдүүлнэ.

#### **2.10.2. Заавар, технологийн мөрдөлт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа**

- ЦУОШГ, ИНЕГ-ын даргын 2011 оны хамтарсан А/450/167 дугаар тушаалаар баталсан "Цаг агаарт зориудаар нөлөөлөх үед агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах" журам, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын А/68, А/11 дугаар тушаалаар 2022 онд баталсан "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журам", Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор баталсан "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм", "Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны заавар"-ыг зөрчсөн тохиолдол бүрд - 2%
- Харвах төрөөрөмж, пуужингийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн журам зөрчсөн тохиолдол бүрд – 5%
- Шуурхай ажиллагааны акт хоцроосон, алдаатай, ирүүлээгүй /3 хоногт багтаан ирүүлнэ/ болон хугацаатай албан бичиг, цаг үеийн мэдээ, тайлан хоцроосон тохиолдол бүрд – 1%

#### **2.10.3. Ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн тайлан**

- Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлсэн үйл ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийж ирүүлээгүй бол -5%
- Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажиллагаа явуулсан сар бүрд нэгээс доошгүй синоптик процессыг үнэлж задлан шинжилгээ хийж ирүүлэх ба ирүүлээгүй тохиолдол бүрд - 5%
- ЦАЗН үйл ажиллагааны тухай мэдээлэлийг байгууллагын даргын зөвшөөрөлөөр, байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулахаас бусад тохиолдолд байгууллагын

албан хаагч, экспедицийн гишүүд өөрийн хувийн хаягаар нийгмийн сүлжээнд мэдээ, баримт, бичлэг оруулсан тохиолдол бүрд - 5%

- ЦАЗН үйл ажиллагааны талаар аймгийн агентлаг болон ААНБайгууллагуудад мэдээллийн цагаар, малчид ард иргэдэд боломжтой цагаар мэдээлэл сурталчилгааны ажил явуулах, сум орон нутгийн иргэдээс сэтгэл ханамжийн талаарх судалгааг авч тайланд тусгах, тусгаагүй бол - 2%
- Технологийн болон үйл ажиллагааны шинэ санал, санаачилга, үр дүн тооцох аргачлал гаргаж үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө Улсын сүлжээ уур амьсгалын үйлчилгээний хэлтэст ирүүлсэн бөгөөд уг санал хэлтсийн хурлаар дэмжигдсэн тохиолдолд 5%-иар нэмэгдүүлнэ. Жилийн ажлын чанар 100%-иас дээш үнэлэгдсэн тохиолдолд тэргүүний экспедицээр шалгаруулна.
- Үйл ажиллагааны нэгдсэн тайланг жил бүрийн 11 дугаар сарын 10-нд багтаан ирүүлэх ба хоцроосон хоног тутам – 2%

**ГУРАВ. УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫН  
ОНЫ ТЭРГҮҮНИЙ ӨРТӨӨ, ХАРУУЛ, ЛАБОРАТОРИ, ЭКСПЕДИЦ,  
НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭ ШАЛГАРУУЛАХ**

**Ерөнхий зүйл**

Аймаг, нийслэлийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажил, улсын сүлжээний нэгжүүдийн анхан шатны ажиглалтын материалд аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөс болон Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Нислэгийн цаг уурын төв, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораториид хийсэн ажиглалтын чанар болон шүүмж шалгалт, орон зайн шалгалтын дүн, ажлын чанарыг харгалзан тухайн оны тэргүүний нэгжүүдийг шалгаруулж шагнана.

**Зорилго:** Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын чанараар тухайн онд амжилт гаргасан улсын сүлжээний оны тэргүүний төв, өртөө, харуул, лаборатори, экспедицийг /цаашид нэгж гэнэ/ шалгаруулахад энэхүү журмын зорилго оршино.

**Оны тэргүүний нэгжүүдийг дараах байдлаар байр эзлүүлнэ. Үүнд:**

- Цаг уурын шинжилгээний өртөөнөөс эхний 3 байр
- Цаг уурын шинжилгээний харуулаас эхний 3 байр
- Ус судлалын харуулаас эхний 3 байр
- Байгаль орчны шинжилгээний лабораториас эхний 2 байр
- Хур тунадас нэмэгдүүлэх экспедицээс эхний 2 байр
- Нислэгийн цаг уурын үйлчилгээ 3 байр
  - Тогтмол нислэгтэй аймгуудаас эхний 1 байр;
  - Тогтмол нислэггүй аймгуудаас эхний 1 байр;
  - Нисэх буудалгүй аймгуудаас эхний 1 байр;

**Шалгаруулах үндсэн үзүүлэлт**

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын тушаалаар баталсан журмын дагуу дүгнэхэд шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын үзүүлэлтээр улсын сүлжээнд тэргүүн байр эзэлсэн байх

- Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн салбаруудаас шинжилгээний ажлын үзүүлэлтээр тэргүүлсэн байх
- Үйлчилгээний ажилд тухайн алба, нэгжийн ажилтны буруугаас шалтгаалсан зөрчил, saatал гараагүй байх
- Ажилтан өөрийн буруугаас багаж, тоног төхөөрөмжид томоохон гэмтэл гаргаагүй байх
- Хууль тогтоомж, төсөв санхүү, өмчийн зөрчил гаргаагүй байх
- Хөдөлмөр хамгаалал, үйлдвэрлэлийн осол гаргаагүй байх
- Орон нутгийн дэмжлэг, хамтын ажиллагааны идэвх санаачилга гаргасан байх

**Материал ирүүлэх**

- Тухайн оны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажил нь тэргүүний нэгжийг шалгаруулах үндэслэл болно.
- Улсын сүлжээний өртөө, харуулын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлыг "Ус цаг уурын өртөө, харуулын шинжилгээний ажлыг дүгнэх журам"-ын дагуу аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төв дүгнэх аймгийнхаа тэргүүний өртөө, харуулыг шалгаруулна.
- Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төв оныхоо тэргүүний нэгжийн тодорхойлолтыг дараа оны 01 дүгээр сарын 05-ны дотор Цаг уур, орчны шинжилгээний

газрын холбогдох хэлтэст ирүүлнэ. Тодорхойлолтод шаардлагатай зураг, материалыг хавсаргасан байна.

### **Тэргүүний нэгжийг шалгаруулах**

- "Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн ажлыг дүгнэх журам"-ын дагуу төвийн мэргэжлийн байгууллагуудаас хийсэн шалгалтын дүн нь тэргүүний нэгж шалгаруулах үндэслэл болно.
- Үзүүлэлт бүрийг 100 хүртэл хувиар үнэлэх бөгөөд нийт дүнг зууны нарийвчлалтайгаар дундажлан гаргана.
- Тэргүүний байрт шалгарах нэгжийн ажлын дундаж хувь тэнцсэн тохиолдолд хамтад нь тэргүүний нэгжүүдээр тооцно.
- Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөс ирүүлсэн тодорхойлолтыг ЦУОШГ болон хүрээлэнгийн холбогдох хэлтсүүд баталгаажуулан хянана.
- Тэргүүний нэгжийг шалгарулсан дүнг ЦУОШГ-ын холбогдох хэлтэс хариуцан хийж 01 дүгээр сарын 15-ны дотор Газрын даргын зөвлөл /ажлын хэсэг /-д танилцуулан газрын даргын шийдвэрээр баталгаажуулна.
- Тухайн жилийн ажлын дүнгээр тэргүүн байр эзэлсэн нэгжид "Тухайн оны тэргүүний нэгж гэсэн өргөмжлөл" олгоно. Сүүлийн 3 жил дараалан оны тэргүүний нэгжээр шалгарсан бол "Улсын тэргүүний нэгж" гэсэн гэрчилгээ олгоно.

----ooOoo----